

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

2025 он

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг, мэргэжлийн, бие даасан, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлын эсрэг, Хүмүүнлэгийн тусламж, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

© Хүүхдийг Ивээх Сан, 2025 он

“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар”-ын тус хэвлэлд орсон бүх текст, зураг, бүдүүвч нь Хүүхдийг Ивээх Сангийн оюуны өмчид хамаарах ба Хүүхдийг Ивээх Санд бичгээр мэдэгдэн зөвшөөрөл авч цаашид боловсруулахад ашиглана уу. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөрийн газраас болон цахим хэлбэрээр www.savethechildren.mn хуудаснаас авах боломжтой.

Зохиогч: Энхбатын Цолмон
Чимэдийн Мөнгөнтуяа
Уртнасангийн Пагма

Хянан тохиолдуулсан багийн гишүүд:
Х.Өлзийтунгалаг, МУБИС, Нийгмийн ажлын тэнхим
Т.Цэндсүрэн, МУБИС, Нийгмийн ажлын тэнхим
Т.Булганзаяа, МУБИС, Нийгмийн ажлын тэнхим

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: mongolia.secretary@savethechildren.org

“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” төслийн хүрээнд Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрөөс боловсруулав.

АГУУЛГА

Өмнөх үг	5
Товчилсон үгийн жагсаалт.	7
Нэр томъёоны тайлбар.	8
Танилцуулга	10
• Үлгэрчилсэн загварын зорилго	10
• Сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд баримтлах зарчим	10
Бүлэг 1. Сургууль, дотуур байрын орчин дахь хүүхэд хамгаалал.	12
1.1. Сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын оролцогч талууд	13
1.2. Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй хүчирхийллийн хэлбэрүүд ба илрэх шинж тэмдгүүд	16
1.3. Эдгээр хүчирхийлэл, дарамтыг хэн үйлдэж болзошгүй вэ?	21
1.4. Хэн өртөж болзошгүй вэ?	22
1.5. Хүүхэд эрсдэлд орсон, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд ЕБС-ийн авах арга хэмжээ	22
1.6. Хүүхэд хамгааллын мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө	24
- Нэгдүгээр шат: Мэдээлэл хүлээн авах үйл явц	25
- Хоёрдугаар шат: Мэдээлэл шилжүүлэх үйл явц	28
- Гуравдугаар шат: Мэдээлэлд хариу арга хэмжээ авах үйл явц	29
- ЕБС, Хамтарсан багийн хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээ	34
1.7. Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч хүүхдүүдийг сургуульдаа эргэн суралцах, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдахад анхаарах асуудлууд	38
1.8. Мэдээлэл хүлээн авах багийн гишүүдийн мөрдөх Ёс зүйн дүрэм	40
Бүлэг 2. Сургууль, дотуур байрын орчин дахь удирдлага, багш ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг.	42
2.1. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сургууль, дотуур байрын удирдлага, багш, ажилтнуудын гүйцэтгэх үүрэг	43
Бүлэг 3. Сургууль, дотуур байрын орчны аюулгүй, хамгаалагдсан байдал	54
3.1. Сургууль, дотуур байрын орчны эрсдэл, аюулгүй байдал ба шалгах хуудас	55
3.2. Гамшиг онцгой байдлын үе дэх сургуулийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын шалгах хуудас.	60
3.3. Сургууль, дотуур байрын орчны эрсдэл, аюулгүй байдлыг бууруулах зөвлөмж	62

Хавсралт	64
1. Монгол Улсад мөрдөгдөж буй хүүхдийн эрх, хамгааллын холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт	.65
2. ХИС-гийн ОУ-ын Эвсэл “Боловсролын үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, журам” удирдамж, 2019 он	.66
Ашигласан материалын жагсаалт	.76
Зураг, хүснэгт, бүдүүвчийн жагсаалт	
Бүдүүвч 1. Хүүхэд хамгааллын мэдээлэл хүлээн авсан даруй сургууль, Хамтарсан багийн ажиллах хүрээ	.32
Бүдүүвч 2. Хүүхэд хамгааллын асуудлын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	.33
Зураг 1. Сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын оролцогч талууд	.13
Хүснэгт 1. ЕБС-ийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны тойм	.23
Хүснэгт 2. ЕБС-ийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийн чиг үүргийн хүрээ.	.34
Хүснэгт 3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд сургуулийн зүгээс эцэг эх, асран хамгаалагчдад өгч болох жишиг зөвлөмж. . . .	.36
Хүснэгт 4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд сургуулийн зүгээс хүүхдэд өгч болох жишиг зөвлөмж	.37

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийг дэмжин, улс орнуудад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэн ажилладаг. Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улсад 1994 оноос Хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын тулд тасралтгүй, тууштай ажиллаж ирсэн. Ингэхдээ сургууль, боловсролын орчинд хүүхдийг зодож шийтгэхийг хуулиар хориглох нөлөөллийн ажлыг үр дүнд хүргэж, хүмүүжлийн эерэг аргыг эцэг эхчүүд, багш нарт түгээн дэлгэрүүлж, 2016 онд Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг боловсруулах үйл явцад техникийн дэмжлэг үзүүлэн ажилласан юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх анхан шатны нэгж болох Хамтарсан багийг дэмжин ажилласан олон жилийн туршлага, Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын эвслийн Кейс менежментийн онол арга зүйн шинэчлэгдсэн цогц удирдамж, Сургуульд баримтлах ёс зүйн дүрэм, Хамгааллын алхмууд, Аюулгүй гэр бүл, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн тайлагналт ба үнэлгээ зэрэг аргачлалуудад үндэслэн төслийг хэрэгжүүлж байна. Төслийн гол зорилго нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд шуурхай тусламж үзүүлэх, хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдал болон эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдийг эрт илрүүлэх, мэргэжлийн байгууллагад холбон зуучлах, нөхөн сэргээх, гэр бүлд нь эргэн нэгтгэх чиглэлээр системтэй тогтвортой, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд оршиж байна. Ингэснээр сургууль, эцэг эх, хүүхэд, Хамтарсан баг гэсэн дөрвөн үндсэн оролцогч талын оролцоонд суурилсан хүүхэд хамгааллын цогц арга зүйг боловсруулж, практикт нэвтрүүлэх нөхцөл бүрдэж байна. Тус “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл нь Улаанбаатар хот болон Ховд, Говь-Алтай аймгийн нийт 14 ерөнхий боловсролын сургууль, 14 Хамтарсан багийн оролцоотойгоор 2023–2025 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газартай хийсэн 3 жилийн хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжиж байгаа тус төслийн хүрээнд боловсролын байгууллагын хамгааллын чиг үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хүүхдийн сурч хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар дэмжихэд сургуулийн багш, ажилтнууд, эцэг эхийг сургах, хүүхдэд эрхийг нь таниулах, эрсдэлийг ойлгуулах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хэнд, хаана, хэрхэн хандахад нь болон үе тэнгийнхэндээ энэ чиглэлээр туслах хүүхдийн чадавхыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Дээрх зорилгоор бид “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар”-ыг боловсруулан танилцуулж байна. Тус цогц гарын авлага нь ерөнхий боловсролын сургуульд НҮБ-ын Хүүхдийн

эрхийн тухай конвенц, түүний 1-р ерөнхий зөвлөмж, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь практик удирдамж болох чухал ач холбогдолтой.

Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсын Засгийн газрын хүүхэд хамгаалалд зориулж буй төсвийг жил тутам нэмэгдүүлж, сургуулиуд хүүхэд хамгааллын төсөвтэй болж байгааг сайшаахын сацуу тус санаачилгыг үр ашигтай, үр дүнтэй, мэргэжлийн арга зүй, зөв төлөвлөлттэй хүүхэд хамгааллын үйл ажиллагаагаар бодитой болгох нь нэн чухал байна.

Бидний боловсруулсан “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар” нь сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулахад та бүхэнд хүүхдийн сайн сайхны төлөө ажиллах олон чухал санаа өгч, олон санаачилгын тань эхлэл байх болно гэдэгт итгэж байна.

Бидний нэгэн адил Монгол Улсын хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд мэдлэг, туршлагаа зориулж байгаа хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түнш байгууллагуудад амжилт хүсье.

Хүүхдийн төлөө зориулсан ажил бүр үр дүнтэй, хөрөнгө оруулалт болгон үр ашигтай байх болтугай.

*Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь Хөтөлбөрийн газрын
Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер
Энхбатын Цолмон*

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СНА	Сургуулийн нийгмийн ажилтан
ХБ	Хамтарсан баг
ХАБХБЖ	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам
ХГБХХХ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс
ХХБ	Хүүхэд хамгааллын баг
ХХтХ	Хүүхэд хамгааллын тухай хууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүүхэд хамгаалал	Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тус хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ. (ХХтХ-ийн шинэчилсэн найруулга 4.1.2 заалт)
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	Хүүхдийн хэвийн өсөлт хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц үл хайхрах, сэтгэл санаа, бие махбод, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. (ХХтХ-ийн шинэчилсэн найруулга 4.1.3 заалт)
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд	Амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхдийг хэлнэ. (ХХтХ-ийн шинэчилсэн найруулга 4.1.4 а заалт)
Сургуулийн Хүүхэд хамгааллын баг	ЕБС бүр хүүхэд хамгааллын багтай байна. ХХБ-ийг сургуулийн захирал ахлах бөгөөд багийн бүрэлдэхүүнд сургуулийн нийгмийн ажилтан, сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, багш нарын төлөөлөл багтана. (БШУС-ын А/457 тоот тушаал “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”)
Хамтарсан баг	Хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хэлнэ. (ГБХТмХ 5.1.4 заалт)
Сургалтын орчин	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн материаллаг болон сэтгэл зүйн нөхцөл, сурах, сургах харилцааг хэлнэ. (БЕХ 3.1.12)
Аюулгүй байдал	Аюул, осол, эрсдэл, гэмтэл бэртлээс хамгаалагдаж байх нөхцөл байдал, бие махбод, хүрээлэн буй орчин, нийгэм, оюун санаа, улс төр, сэтгэл зүйн хоригдлоос ангид байх хүмүүсийн бие махбодын, хувь хүний сайн сайхан, бүрэн бүтэн байдлыг хэлнэ. (MNS 6948:2021)

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах	Байгууллага тэдний ажилтан хэрэгжүүлж буй хөтөлбөр үйл ажиллагаа, хөтөлбөр нь хүүхдэд гэм хор учруулахгүй байхыг хариуцах байдлыг хэлнэ (Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, MNS 6948:2021)
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	Хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ. (ХХтХ-ийн шинэчилсэн найруулга 4.1.9 заалт)
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй, орон нутгийн олон талт орон тооны бус нэгжийг хэлнэ. (ХХтХ-ийн шинэчилсэн найруулга 4.1.10 заалт)
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд	ХХтХ-ийн шинэчилсэн найруулгын 4.1.5-р зүйл: • 1.5а гэмт хэрэг зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд; • 1.5б өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч; • 1.5в зөрчилд холбогдогч хүүхэд; • 1.5г зөрчил үйлдэж шийтгэгдсэн, эрүүгийн хариуцлага хүлээсэн, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд; • 1.5д иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад 2023-2024 оны хичээлийн жилд нийт 871 ерөнхий боловсролын сургуульд (ЕБС) 771.7 мянган хүүхэд суралцаж байгаагийн 36,029 нь сургуулийн дотуур байранд амьдарч байна.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын (2024 он) 2.3.2-т боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авах арга хэмжээнүүдийг заасан.

Эдгээр заалтуудыг практикт үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ үлгэрчилсэн загварыг Японы Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл (2023-2025 он)-ийн хүрээнд сургуулийн удирдлага, багш, ажилтнуудыг өөрийн сургуулийн онцлогт тохируулан ашиглаж болохуйц байдлаар бэлтгэн танилцуулж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагууд уг загварыг ашиглахдаа нийт багш, ажилтнуудынхаа ажлын байрны тодорхойлолтод хүүхэд хамгаалахад гүйцэтгэх үүргийг тусган нэгдсэн төлөвлөлтөө энэ мэт боловсруулж ажиллавал тухайн сургуулийн хүүхэд хамгааллын механизм нь хүний нөөцийн бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран тогтвортой ажиллах бололцоотой болохыг Хүүхдийг Ивээх Сангаас зөвлөж байна.



Үлгэрчилсэн загварын зорилго

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний Нэмэлт 3 протокол, Боловсролын ерөнхий хууль (2023), Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2024) болон хүүхдийн эрх, хамгааллын холбогдолтой бусад эрх зүйн актуудыг ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх практик арга зүй бүхий жишиг загварыг бий болгох явдал юм.

Энэхүү загварыг ашиглахдаа Хүүхдийн Эрхийн Конвенцийн суурь зарчмуудад үндэслэсэн дараах зүйлсийг мөрдлөг болгоно. Үүнд:



Хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчим. Хүүхдийн асуудалтай холбоотой аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд харгалзан үзэж, хүүхдийн сэтгэлзүй, сэтгэл санаа, бие махбодын хэрэгцээ, аюулгүй байдал, эрүүл мэнд болон сайн сайхан байдлыг хангахыг эрхэмлэнэ.



Үл ялгаварлах. Хүүхэд хэн болох, хаана амьдардаг, эцэг эх, асран хамгаалагч нь хэн байх, ямар ажил хийдэг, ямар шашин шүтдэг, хүйс, соёлын онцлог, эдийн засгийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран тэдэнд ижил тэгш хандаж, шаардлагатай дэмжлэг, тусалцааг үзүүлнэ.



Аюулгүй байдлыг хангах. Мэдээллийн мөрөөр хийх ажиллагаа нь хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүсгэж болзошгүй. Хүүхдийн амь нас аюулд орсон байж болзошгүй нөхцөл илэрсэн, эсхүл энэ талаар мэдээлэл авсан тохиолдолд яаралтай цагдаагийн байгууллагад хандана. Шаардлагатай бол хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулахад дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд нүдэнд харагдахгүй, гаднаас нь хараад мэдэгдэхгүй гэмтэл авсан байж болзошгүй тул сайтар ажиглаж, эрүүл мэндийн тусламжид холбоно.



Хариуцлагатай байх. Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээлэл бүрийг нухацтай авч үзэж, хэрхэн арга хэмжээ авсан, шийдвэрлэсэн тухай хариуг өгөх ёстой. Өөрөөр хэлбэл тодорхой байна гэсэн үг. Мэдээллийг албан ёсоор ирүүлсэн бол хүлээж авснаа мэдэгдэж, ямар хугацаанд шийдвэрлэх талаар хариу өгнө. Албан ёсны мэдээлэл ирүүлээгүй ч хүүхдийн яриа, зан үйлийн илрэлээс асуудал байгааг анзаарсан тохиолдолд ч мөн адил хариуцлагатайгаар хандаж, цаашид ямар арга хэмжээ авах, юу хийх талаар хүүхдэд мэдэгдэх ёстой. Мэдээлэл нь сургуульд хамааралгүй бол шаардлагатай дэмжлэг үзүүлж чадах мэргэжлийн байгууллагад холбож өгнө.



Цаг алдахгүй байх. Хүүхдийн наснаас хамаарч цаг хугацааны мэдрэмж нь насанд хүрэгчдийнхээс өөр байдаг. Нэг сарын хугацаа тэдэнд үүрд мөнх мэт санагдаж мэднэ. Хүүхдийн хувьд хэдэн сар сургуулиа орхих, хэдэн долоо хоног дээрэлхүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахгүй байх зэрэг нь урт хугацааны сөрөг үр дагаварт хүргэдэг. Тиймээс тэдэнд үзүүлэх үйлчилгээ нь илүү хурдтай, цаг алдалгүй хүрэх ёстой.



Хувийн нууц ба нууцлалыг хамгаалах. Хүүхдийн аюулгүй байдалтай холбоотой зөрчил, мэдээлэл, шалгах үйл ажиллагаа нь зөвхөн мэдэх шаардлагатай зүйлийг л асуух зарчмаар хэрэгжих бөгөөд холбогдох бүхий л мэдээллийг нууцална. Үүнтэй адилаар, энэ асуудалтай холбоотой бүхий л харилцаа нууц бөгөөд аюулгүй байна.

Санамж: Энэхүү үлгэрчилсэн загвар нь үүрэг хүлээгчдэд зориулсан бөгөөд хүүхдэд сэдэл өгч болохуйц хүчирхийлэл, мөлжлөгийн хэлбэр, илрэлүүдийн талаар дурдагдах тул анхааралтай ашиглана уу.

БҮЛЭГ 1

**СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧИН ДАХЬ
ХҮҮХЭД ХАМГААЛАЛ**

Сургууль, дотуур байрын орчин: Энэхүү гарын авлагад сургууль, дотуур байрын орчныг материаллаг ба материаллаг бус гэж ангилж үзэв.

Материаллаг орчин гэдэгт сургууль, дотуур байрын дотоод орчин, эргэн тойрон 150 метр¹ хүртэлх гадна орчин, мөн түүнчлэн сургууль, эцэг эхийн зөвлөл, анги хамт олны зүгээс сургуулийн бүсээс өөр газарт зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагааны талбарыг ойлгоно. Үүнд сургуулийн барилга байгууламж, анги танхим, бие засах газар, биеийн тамирын болон бусад заал, бүх багш, ажилтнуудын ажлын өрөө, номын сан, гал тогоо, цайны газар, коридор, сургуулийн автобус, гаднах талбай, дотуур байр, арга хэмжээ зохион байгуулж байгаа бусад газрууд багтана.

Материаллаг бус орчин гэдэгт хүүхэд, багш ажилтнууд болон сургуулийн орчинд ажилладаг хүмүүсийн хоорондын нийгэм, сэтгэл зүйн харилцаа, ёс зүйн хэм хэмжээ багтана. Сургуулийн цахим хуудас, сургуультай холбогдолтой нийгмийн сүлжээ, багш, ажилтнууд, сурагчид, эцэг эхчүүдийн цахим хуудаснууд зэрэг хүүхдийн асуудлаар бичигдэх, хуваалцагдах, мэдээлэгдэх талбаруудыг хамарна.

Хүүхэд хамгаалал: Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ.

1.1. СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧИНД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

ЕБС, дотуур байрын аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын асуудлаас сэргийлэхэд олон талын оролцогчдын хамтын хүчин чармайлт шаардлагатай.

Сургуулийн удирдлагын хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангах тууштай анхаарал, ажилтнуудын сонор сэрэмж, хүүхдийн идэвхтэй оролцоо, эцэг эхийн дэмжлэг, хамтын ажиллагаа зэрэг нь хүүхдүүдийг хамгаалах хүчирхэг сүлжээг бий болгодог.

Энэ сүлжээ нь дотоод хяналтын багаар дамжуулж, аюулгүй байдлын үнэлгээг

Зураг 1



1 Газрын тухай хууль (2002 он)-ийн 33.1.1 дүгээр заалт

тогтмол хийж, дүгнэлтийн дагуу тасралтгүй сайжруулалт хийснээр хүүхэд бүрийн сайн сайхныг хангах хамгийн өндөр стандартыг ч хангах боломжтой болох юм.

Сургуулийн хүүхэд хамгааллын оролцогч талуудын хамтын ажиллагаа нь хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эрхийг хамгаалах, хүчирхийллийг илрүүлэх, арга хэмжээ авах, сургууль дотуур байрны орчныг аюулгүй, тогтвортой болгоход зайлшгүй шаардлагатай.



Сургуулийн удирдлага: Хүүхэд хамгааллын үндэс суурь

Сургуулийн удирдлага нь сургуульдаа хүүхэд хамгааллын үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхэд дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Сургуульдаа Хүүхэд хамгааллын бодлого журмыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, нөөцийг хуваарилан хэрэгжилтийг хангах;
- Шинэ ажилтан авахдаа өмнөх ажлын түүхийг сайтар судлан, хүүхэд хамгааллын бодлого журамтай танилцах, чиглэл, заавар өгөх;
- Нийт багш, ажилтнуудыг хүүхэд хамгаалахад гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхэд дэмжих;
- Хүүхэд хамгааллын баг (ХХБ)-ийн үйл ажиллагааг тогтмол, үр дүнтэй ажиллуулахад манлайлал үзүүлж, дэмжинэ.



Багш, ажилтнууд: Сонор сэрэмж, бэлэн байдал

Сургууль дээр өдөр тутам хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багш, ажилтнууд тэргүүн эгнээнд зогсдог. Тэд сонор сэрэмжтэй байж, болзошгүй эрсдэлийг тодорхойлж, шийдвэрлэх, анхны тусламж үзүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд яаралтай хариу арга хэмжээ авах Хүүхэд хамгааллын бодлого журмыг судалсан байх ёстой. Мөн гамшиг, онцгой байдлын сургуулилтад идэвхтэй оролцож, завсарлагааны үеэр болон бусад үйл ажиллагааны үеэр хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, тэдэнд эерэг, зөв зан үйлийг үлгэрлэн сурталчлах нь чухал.



Хүүхэд: Хамгааллын идэвхтэй оролцогчид

Хүүхдүүд өөрсдийгөө болон үе тэнгийнхнээ хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний тулд хүүхдүүдэд дараах үр чадваруудыг олгох шаардлагатай. Үүнд:

- Өөрийн эрхийг мэддэг, аюулгүй, хамгаалагдсан байдал гэж ямар нөхцөл байдлыг хэлдэг болохыг ойлгодог байх;
- Аюулгүй нөхцөл байдлыг таних, аюултай байж болзошгүй нөхцөл, зан үйлийг тодорхойлж сурах;
- Өөрийгөө аюултай байдалд орсон гэж бодож байгаа, эсвэл хэн нэгэн эрсдэлт нөхцөлд байгааг харсан, сонссон, мэдэрсэн бол түүнийг хэрхэн мэдээлэх, хаанаас, хэнээс тусламж авч болохыг мэддэг байх;
- Хүүхэд хамгааллын сургалт хөтөлбөрт оролцож, хувийн аюулгүй байдал, хил хязгаар, эрүүл харилцаа, цахим орчны аюулгүй байдлын талаар ойлголт авах;
- Үе тэнгийнхэндээ шаардлагатай үед тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг багтана.



Эцэг эх, асран хамгаалагч: Хамтын ажиллагаа ба харилцаа холбоо

Эцэг эх, асран хамгаалагч нь сургууль, багш, ажилтнуудтай ойрхон байж, хамтран ажилласнаар сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хүчтэй оролцогч тал болж чаддаг байна.

Эцэг эхчүүдийн оролцооны чиглэл:

1. Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголттой байх
 - Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого, журамтай танилцсан байх;
 - Хүүхдэдээ өөрийнхөө аюулгүй байдлыг хангах, хил хязгаар тогтоох, тулгамдсан асуудлаа мэдээлэх талаар зааж сургах.
2. Оролцох ба харилцаа холбоотой байх
 - Хүүхэд хамгааллын талаарх сургуулийн уулзалт хуралд оролцож, цаг үеийн мэдээлэлтэй байх;
 - Хүүхэд болон сургуультай холбоотой аливаа асуудал, ажиглалтын талаар нээлттэй харилцаж, мэдээлэл солилцдог байх.
3. Дэмжлэг ба хамтын ажиллагаа сайтай байх
 - Хүүхэд хүчирхийлэл, үл хайхралд өртөж байгаа талаар сэжиг, таамаг, мэдээлэл байвал сургууль болон холбогдох бусад байгууллагад мэдээлэх;
 - Хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн сургуулиас явуулж байгаа хөтөлбөр, санаачилгад оролцох зэрэг багтана.



Хамтарсан баг: Хариу үйлчилгээ

Хамтарсан баг нь төрийн үйлчилгээний анхан шатны нэгж дээр хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээ үзүүлэх бүтэц юм. Тухайн нутаг дэвсгэр дээр хүүхэд хамгааллын асуудал гарсан тохиолдолд хуулийн хүрээнд Хамтарсан баг анхан шатны үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй учраас сургуулийн хүүхэд хамгааллын оролцогч талуудын нэгд зүй ёсоор тооцогддог.



Сургуультай холбоотой бусад хүмүүс: Дэмжлэгийн сүлжээ

Сургуультай холбоотой бусад хүмүүс гэдэгт дадлагажигч болон гэрээт багш, зөвлөх, гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, зочид төлөөлөгч, сайн дурынхан, тухайн сургууль дээр хэрэгжиж буй төслийн ажилтнууд багтана. Тэд хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлүүд, түүний шинж тэмдэг, илрэх байдлын талаар мэдлэгтэй байж, өөрөө түүнийг үйлдэхээс ямагт татгалзаж, хүүхэд хүчирхийлэлд өртсөн болохыг мэдсэн, сэжиглэсэн, таамагласан тохиолдолд сургуулийн Хүүхэд хамгааллын багт шууд мэдээлэх идэвхтэй оролцоо нь хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг сайжруулахад тустай.



Хяналт, үнэлгээ: Тасралтгүй сайжруулалт

Сургууль хүүхэд хамгааллын бодлого журам, хууль, дүрмийн дагуу төлөвлөсөн үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай, хүүхдэд ээлтэй явуулж чадсан эсэхээ тогтмол үнэлж байх шаардлагатай. Тогтмол үнэлэх нь үйл ажиллагааг улам сайжруулах ач холбогдолтой.

Хяналт үнэлгээг хийхдээ хөндлөнгийн болон дотоод хяналт үнэлгээ хийж ажиллах нь тохиромжтой байдаг. Хяналт, үнэлгээтэй холбоотой зардлыг хүүхэд хамгааллын төсөвт зайлшгүй тусгана. Хөндлөнгийн хяналт үнэлгээг хүүхэд хамгааллын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэшсэн байгууллага, мэргэжилтнүүдээр хийлгэж болно. Хөндлөнгийн хяналт шалгалтыг 2 жил тутамд, дотоод хяналт шалгалтыг жил бүр хийж, зөвлөмжийн дагуу сайжруулалт хийж ажиллах нь үйл ажиллагаагаа улам сайжруулахад тустай.

Мөн мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ үзүүлж буй Хүүхэд хамгааллын баг (ХХБ) болон бусад багш, ажилтнууд нь сургуулийн хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор бага, дунд, ахлах ангийн хүүхэд, багш ажилтнууд, эцэг эхээс давтамжтай асуулга, судалгааг авдаг байх нь хяналт, үнэлгээний чухал ач холбогдолтой.

1.2. СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧИНД ҮЙЛДЭГДЭЖ БОЛЗОШГҮЙ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ХЭЛБЭРҮҮД¹ БА ИЛРЭХ ШИНЖ ТЭМДГҮҮД

БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Хүүхдийн бие махбодод шууд халдах хүчирхийллийн явцуу хэлбэрээс гадна хүүхдийн хэвийн хөгжилд саад болох олон талт нөлөөг тооцон өргөн хүрээнд тодорхойлно.	- Хүүхдийг бие засуулахгүй байх; - Ус уухыг хориглох (олон дахин бие засах, ширээн дээр асгахаас тээршээх); - Шийтгэх болон бусад зорилгоор хоол идүүлэхгүй байх; - Хоцроход нь сургууль болон ангид оруулахгүй байх; - Сургууль дээр бусдын дэргэд дотор (гадуур хувцаснаас бусад) хувцсаа тайлахыг шаардсан нөхцөл байдалд оруулах; - Хоолыг нь өгөхдөө шидэх гэх мэтээр хүүхэдтэй доромж байдлаар харьцах; - Зодох – алгадах, цохих, чимхэх, хатгах, ороолгох, өшиглөх, үснээс зулгаах, эд юмаар цохих, түлхэж унагах, чичих; - Дэглэх – галуун цуваагаар алхуулах, гарыг нь өргүүлэх, сандал, цүнх зэрэг эд зүйлс өргүүлэх; - Хэн нэг эцэг эх, асран хамгаалагч өөрийн хүүхдээ өмөөрөх болон бусад шалтгаанаар сурагчийн биед халдах болон бусад.	- Ил харагдах бэртэл гэмтэл; - Хөхрөлт, улайлт, хавдалт, түлэгдсэн, хазуулсан, зүсэгдсэн шарх; - Үс, арьс нь зулгарч, халцарсан; - Өмнө нь олон удаа гэмтэж байсан ул мөр, сорви илрэх; - Огцом хөдөлгөөнөөс цочиж далдичдаг болон үүгээр хязгаарлагдахгүй.

¹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2024 он)-ын 1.3 дугаар заалтад дурдагдсан хэлбэрүүд

СЭТГЭЛ САНААНЫ ДАРАМТ/ХҮЧИРХИЙЛЭЛ		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Хүүхдийг үл хайхрах хандлагаас эхлээд хүүхдийн өсөлт хөгжлийн хэвийн байдлыг хангах үүргээсээ татгалзах хүртэл хүүхдийн сэтгэл санаанд дарамт үзүүлэх бүхий л хандлага, зан үйл бүгд сэтгэл санааны хүчирхийлэлд хамаарна.	- Хүүхдэд нэр хоч өгч, харааж загнах; - Гутаан доромжлох; - Ялгаварлан гадуурхах; - Хэн нэг хүүхдэд бусдаас давуу байдал олгох; - Хэн нэг хүүхдийг шударга бусаар үнэлэх; - Дүнгээр хавчих; - Заналхийлэх, дарамтлах; - Ангиас болон сургуулиас хөөх; - Асуудлаа хэлээд хандсан хүүхдийг өөрийг нь буруутгах; - Өөр ангид оруулж, гаргасан зөрчлийнх нь талаар бусад хүүхдүүдийн өмнө хэлж ичээх байдлаар шийтгэх; - Хичээлд хэрэглэх үнэтэй зүйлс авчрахыг шаардах; - Хурааж буй мөнгийг хүүхдээс нэхэх; - Хэн нэг эцэг эх, асран хамгаалагч өөрийн хүүхдээ өмөөрөх болон бусад шалтгаанаар сурагчийг үг хэлээр дайрч доромжлох; - Багш, сургуулийн ажилтнуудын зүгээс үе тэнгийн дээрэлхэл гарсныг мэдсээр байж арга хэмжээ авахгүй байх; - Хүүхдийг аливаа уралдаан тэмцээнд оролцуулахдаа амжилт үзүүлж, сургуулийн нэрийг сайнаар гаргах үүрэг хүлээлгэх, амжилт үзүүлээгүй тохиолдолд буруутай мэдрэмж төрүүлэх зэргээр сэтгэл санааны дарамт үзүүлэх болон бусад.	- Сэтгэл санаа нь тогтворгүй байх; - Үгэнд хэт оромтгой; - Бусдаас хэт их халамж, анхаарал хүсэх; - Биеэ хэт сайн авч явахыг эрмэлзэх; - Хийсэн үйлдлийнхээ үр дагавраас айх, үүнээсээ болж худал хэлэх; - Өөрийгөө хэт дорд үзэх, голох; - Үгэнд хэт оромтгой, бусдыг ая талыг харамтгай байх; - Сэтгэл гутралд орох болон үүгээр хязгаарлагдахгүй.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэн хүүхдийг бэлгийн дур хүслээ хангах зорилгоор бэлгийн аливаа үйлдэлд ашиглахыг хэлнэ. Хүүхдийг өөрийн бэлгийн дур хүсэл, сонирхлыг хангах, ашиглах зорилгоор бэлгийн аливаа үйлдэлд зориуд татан оролцуулах, ашиглах аливаа үйлдлийг хэлнэ.	- Хүүхдийн биед хүрэх, илж таалах; - Хэт ойрхон зогсох (50см-ээс дотогш); - Задгай хувцаслаж хүүхдийн анхаарлыг татах, өдөөн хатгах; - Хувийн илэн далангүй зураг, бичлэгээ хүүхэд рүү явуулах, хүүхдээс зураг бичлэгээ өгөхийг хүсэх, шаардах; - Шалиг үг яриа ярих, бусдыг ийм үйлдэл хийж байхад хориглож зогсоохгүй байх, дэвэргэх; - Ёс зүйгүй, задгай яриа, агуулга, хувцаслалттай урлагийн тоглолт, жүжиг, дүрийн тоглолт болон насанд хүрэгчдийн контентыг сургууль, дотуур байрны орчинд тоглуулахгүй, ашиглуулахгүй байх; - Хүүхдийг бэлгийн харилцаанд оруулах, уруу татах; - Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд оруулсан, энэ үйлдлээ сургууль, дотуур байрны орчинд болон сургуультай хамааралтай насанд хүрсэн хүн хувийн цахим сүлжээгээр дамжуулж хүүхдийг эрсдэлд оруулах; - Сургуулиас гадуур хүүхэдтэй ганцаарчлан уулзах, гэртээ урих, дуудах; - Сургууль дээр шаардлагагүй тохиолдолд хүүхэдтэй 1:1-ээр удаан хамт байх болон бусад.	- Явах, суухад хүндрэлтэй байх; - Биед нь хүрэхэд айж цочих; - Бэлгийн үйлдлийг хэт сонирхох; - Бусадтай хөгжилдөж чадахгүй болох; - Гэртээ болон ямар нэг газар байхаас айх, эсрэг хүйсийн хүнээс айх; - Анхаарал төвлөрөлт эрс сулрах; - Гөлрөнгө, дуугүй болох; - Сэтгэл санаа нь тогтворгүй болох; - Тайван унтаж чадахгүй байх; - БЗХӨ тусах; - Жирэмслэх; - Амиа хорлох, өөрийгөө гэмтээх оролдлого хийх болон үүгээр хязгаарлагдахгүй.

ҮЛ ХАЙХРАХ БАЙДАЛ		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг үл тоон, анхаарал халамж хангалтгүй үзүүлсний улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэндэд нь хохирол учруулахыг хүүхдийг үл хайхрах явдал гэнэ.	- Чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэх ёстой үүргээ санаатай болон санамсаргүй байдлаар биелүүлэхгүй, эсвэл орхигдуулах; - Хүүхдийг сонсохгүй, санал бодлыг нь чухалд авч үзэхгүй байх; - Хүүхэд өөрөө болон бусад хүн хүүхдийн асуудлаар мэдэгдэж тусламж хүсэхэд цаг алдалгүй хариу арга хэмжээ авахгүй байх; - Орчны аюулгүй байдлыг байнга хянахгүй, тогтмол засаж сэлбэхгүй байх; (ариун цэврийн өрөөний хаалга цоожны эвдрэл гэмтлийг засахгүй байх... гэх мэт) - Бие нь өвдөж байгаагаа илэрхийлсэн хүүхдийн шалтгааныг хүлээж авахгүй байх, хүчээр хичээлд (биеийн тамир гэх мэт) оруулах; - Сургуулийн орчинд баяр тэмдэглэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, тамхи татах гэх мэтийг насанд хүрэгчид биеэр хүүхдэд үлгэрлэх; - Хүүхдийн тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх эрсдэлд оруулах. Тухайлбал, хурдан морины өвөл, хаврын уралдаанд оролцох гэж буй хүүхдэд хичээлийн чөлөө өгөх гэх мэт. - Хүүхдүүд нэгнээ дээрэлхэж байхад мэдсэн хэр нь асуудлыг шийдвэрлэхгүй, тоохгүй орхих болон бусад.	- Хүүхэд хараа хяналтгүй байх; - Улиралдаа тохирохгүй хувцас өмсөх; - Бусдаас хэт их халамж, анхаарал хүсэх; - Шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээ авахгүй байх; - Байнга өлссөн, цангасан, ядарсан байх; - Эцэг эхийн үүргийг орлож, дүү нараа өсгөн хүмүүжүүлэх үүрэг хүлээх; - Эрүүл ахуй, хувийн ариун цэвэр муу, арьсны халдварт өвчнөөр өвчилсөн байх болон үүгээр хязгаарлагдахгүй.

ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛ ¹		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Нэг буюу хэд хэдэн хүүхэд нөгөө нэг буюу хэд хэдэн хүүхдийг санаатайгаар, удаа дараа давтагдан, бие махбод болон сэтгэл санаанд нь хор хохирол учруулах, зовоох, ялгаварлан гадуурхах, тусгаарлах, айлган сүрдүүлэх эсвэл заналхийлэх зорилгоор биеэр, амаар, харилцааны аргаар болон цахим орчинд үйлдсэн аливаа үйлдлийг хэлнэ.	- Цахимаар болон биечлэн хэл амаар доромжлох; - Зориуд ганцаардуулж гадуурхах; - Цохиж, зодох, унагах, түлхэх; - Нэр хоч өгөх, олны дунд худал цуурхал тарааж гүтгэх; - Хувийн зураг, бичлэгийг нь олонд дэлгэх, шоолох; - Айлган сүрдүүлэх, заналхийлэх; - Мөнгө, эд зүйл нэхэх, утас, үнэт эдлэлийг нь барьцаалуулж, зээл авхуулах; - Доромж үгээр дуудах, нэр төрийг нь гутаах; - Олны өмнө зориудаар ичгэвтэр байдалд оруулах; - Хүсээгүй зүйлийг нь хүчээр хийлгэх – хичээл, бие даалтаа хийлгэх, архи уулгах, тамхи татахыг шаардах, аливаа мансууруулах бодис хэрэглэхийг тулгах, ятгах, хүч хэрэглэн хэрэглүүлэх, сүрдүүлэх болон бусад.	- Ганцаардах; - Дуугаа хураах; - Өөрийгөө гэмтээх оролдлого хийх; - Сэтгэлээр унах; - Түгших; - Тайван унтаж чадахгүй байх; - Санаа зовж, сэтгэл санаа нь тогтворгүй байх; - Уур уцаартай болох болон үүгээр хязгаарлагдахгүй.

1 Хүүхэд хамгааллын тухай хууль (2024 он)-ийн 1.7-р заалт

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР		
Тодорхойлолт	Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдэж болзошгүй түгээмэл хэлбэр	Илрэх шинж тэмдэг
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр ¹	Боолчлолын бүх хэлбэр болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараах үйл ажиллагаа хамаарна: (а) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох; (б) олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, хил дамжуулан худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох; (в) ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил.	• Өвөл, хаврын уралдаанд морь унуулах; • Морь унуулахын тулд хичээлээс нь чөлөө авах, таслуулах; • Ажлын хөлсийг нь өгөхгүй байх, маш бага өгөх; • Гэмтэж бэртсэн, өвдсөн үед нь эмчлүүлэхгүй байх; • Ажлын хөлсийг нь өөр хүн авах, хүүхдэд өгөхгүй байх; • Эсэргүүцсэн тохиолдолд зодох, дарамтлан сүрдүүлж, хүчээр ажиллуулах; • Хэт олон цагаар, хүнд нөхцөлд ажиллуулах; • Хоол цай өгөхгүй байх, унтуулахгүй байх болон үүгээр хязгаарлагдахгүй. • Дотуур байранд хүүхдийг өөрийн хүсэлгүйгээр тусгаарлах, зоригийг нь дарж, эрх чөлөөг нь хязгаарлах. • Хүүхдийг сургуулийн болон дотуур байрны ажилд хүчээр оролцуулах, цагийн хязгаар, нас, чадварын тохиромжгүй ажил хийлгэх.



Анхаар:

Дээрх хүчирхийллийн төрлүүд нь дангаар үйлдэгддэггүй, харилцан хамааралтай явагддаг. Жишээлбэл, бие махбодын хүчирхийлэлд өртөж буй хүүхэд сэтгэл санааны хүчирхийлэлд давхар өртдөг, бэлгийн хүчирхийлэл нь бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн аль алиныг нөхцөлдүүлдэг байна.

1.3. ЭДГЭЭР ХҮЧИРХИЙЛЭЛ, ДАРАМТЫГ ХЭН ҮЙЛДЭЖ БОЛЗОШГҮЙ ВЭ?

- Хүүхдийн таньдаг болон танихгүй насанд хүрэгчид;
- Багш, дадлагажигч багш, сайн дурынхан;
- Сургуулийн ажилтнууд;
- Эцэг эх, асран хамгаалагч;
- Сургуулийн гэрээт гүйцэтгэгчид;
- Сургуулийн зочид;

1 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц

- Үе тэнгийнхэн;
- Сургууль дээр төсөл хэрэгжүүлж буй байгууллагын ажилтнууд;
- Цахим гэмт хэрэг үйлдэгчид болон үүгээр хязгаарлагдахгүй.

1.4. ХЭН ӨРТӨЖ БОЛЗОШГҮЙ ВЭ?

Нийт хүүхдүүд, тэр дундаа дараах эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүд илүү эмзэг, өртөмтгий байдаг. Үүнд¹:

- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхэд;
- Хүчирхийлэл үйлдэгч төрлийн зан төлөвтэй, бэлгийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй эрсдэл бүхий хүмүүстэй амьдарч буй хүүхэд;
- Цахим орчны эрсдэлд өртсөн хүүхэд;
- Зан үйлийн өөрчлөлттэй, өөртөө хохирол учруулах, амиа хорлох, сэдэл гаргаж байсан хүүхэд;
- Гэрээсээ дайжсан хүүхэд;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай хүүхэд;
- Орон гэргүй хүүхэд;
- Хүн худалдаалах гэмт хэрэгт болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд;
- Асрамж халамжийн төвд амьдардаг хүүхэд;
- Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхтэй хүүхэд;
- Сэтгэцийн өвчтэй эцэг эхтэй хүүхэд;
- Архи болон мансуурах бодисын хамааралтай эцэг эхийн хүүхэд;
- Насанд хүрээгүй эцэг эх болсон хүүхэд;
- Өсвөр насны жирэмсэн охид.

1.5. ХҮҮХЭД ЭРСДЭЛД ОРСОН, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ТОХИОЛДОЛД ЕБС-ИЙН АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 тоот тушаал “ЕБС, дотуур байранд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-д сургууль бүр хүүхэд хамгааллын багтай байна. Багийг сургуулийн захирал ахлах ба бүрэлдэхүүнд нь нийгмийн ажилтан, сургалтын менежер, сэтгэл зүйч, эмч, анги удирдсан багш нарын төлөөлөл багтана гэж заасан. Тус журмаар ХХБ нь сургуулийн орчинд хүүхэд хамгааллын асуудлууд гарсан тохиолдолд шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ² үзүүлэх үүрэг хүлээсэн.


Дээрх журмын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургуулиудад “Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө” – ний загварыг 1.6-д 3 үйл явц болгон танилцуулж байна. Энэхүү үйл явц нь хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээний 3 хэлбэрийг хэрэгжүүлэхэд сургууль, дотуур байрын орчинд авч хэрэгжүүлэх практик саналуудыг багтаасан байдлаар боловсруулагдсан болно.

¹ Сургуулийн нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага (ХЗДХЯ, АХБ, 2023 он)

² Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2024)-ын 4 дүгээр зүйл

Хүснэгт 1

Ерөнхий боловсролын хүүхэд хамгааллын үйлчилгээний тойм



1.6. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



Зорилго:

Сургууль, дотуур байрын орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэлт мэдэгдсэн, үйлдэгдсэн, сэжиглэгдсэн талаарх мэдээллийг хүлээн авах, шилжүүлэх, хариу арга хэмжээ авах үйл явцыг зохион байгуулах практик удирдамж юм.

Сургууль, дотуур байрын орчинд үйлдэгдсэн гэдэгт сургууль, дотуур байрын дотор болон эргэн тойрон 150 метр хүртэлх зай, сургуулийн автобусанд, хичээлээс гадуурх урлаг, спортын тэмцээн, олимпиад, клуб, дугуйлан, сургуулиас зохион байгуулж буй нийтийн цэвэрлэгээ, мод тарих, төгсөлт болон бусад баяр¹-ын арга хэмжээ гэх мэт сургууль, дотуур байрын бүсээс өөр газар явагдаж буй үйл ажиллагааны үеэр хүүхдийн эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх зэргийг ойлгоно.

Сургууль, дотуур байрын орчинд таамаглагдсан болон мэдэгдсэн гэдэгт хүүхэд дээр дурдагдсанаас бусад орчинд эрх нь зөрчигдөж, бүх төрлийн хүчирхийлэлд өртсөн, үйлдсэн, оролцсон, гэрчилсэн зэргийг сургууль, дотуур байрны орчинд байхад хүүхэд, багш, ажилтнууд мэдэх, эсвэл энэ тухай сургуулийн хүүхэд хамгааллын баг мэдээлэл хүлээж авахыг ойлгоно.

Сургуулийн удирдлага нь сургууль, дотуур байрын орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийн үйлдэгдсэн, илэрснийг харсан, мэдсэн, сэжиглэсэн, таамагласан хүүхэд, эсвэл насанд хүрэгчдээс мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ авах дараах үйл явц хэрэгжүүлнэ.



Үйл явц тус бүрийн дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн дэд хэсгээс үзнэ үү.

¹ Хүүхдийн орчинд насанд хүрэгчид баяр тэмдэглэх, архи, тамхи, согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.

1 Мэдээлэл хүлээн авах үйл явц

1. Мэдээлэл гэж юу вэ?
2. Мэдээллийг хэрхэн хүлээн авах вэ?
3. Мэдээллийг хэн хүлээн авах вэ?
4. Мэдээллийг хэрхэн зохион байгуулах вэ?

Нэгдүгээр шат: Мэдээлэл хүлээн авах үйл явц

1. “Мэдээлэл” гэж юу вэ?

Энэхүү баримт бичигт “мэдээлэл” гэдгийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн байж болзошгүй болон үйлдэгдсэн талаарх хүүхэд, насанд хүрэгч, бусад этгээдээс аливаа нотлох баримт шаардахгүйгээр ирүүлсэн мэдээлэл, санал, хүсэлт, өргөдөл гомдол зэргийг ойлгоно.

2. Мэдээллийг хэрхэн хүлээн авах вэ?

Сургууль мэдээлэл хүлээн авах сувгуудтай байх бөгөөд энэ нь хүүхдийн хөгжлийн болон хувийн онцлогт тохирсон, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд ашиглаж болохуйц, хандахад хялбар олон төрөл хэлбэртэй, нууцлалыг хадгалсан, түргэн шуурхай арга хэмжээ авахуйц байна.

Мэдээлэл хүлээн авахад түгээмэл ашиглагддаг 3 төрлийн сувгийг танилцуулбал:

	Албан ба албан бус нүүр тулсан уулзалт, ярилцлагаар	Мэдээлэл өгч буй хүн биеэр ирж уулзах, хүнээр дамжуулан мэдээлэл өгөх зэргийг ойлгоно.
	Бичгээр	Сургуулийн - Саналын хайрцаг - QR код - И-мэйл хаяг - Пэйж хуудасны чат Шуудан болон хүнээр хүргэгдэн ирсэн захидал зэргийг ойлгоно.
	Утсаар	Мэдээлэл өгч буй хүн утсаар ярих, мессеж бичих, дуу хураагуурт яриа үлдээх, дуут, дүрст мессеж илгээх болон 108 утсаар дамжин ирсэн мэдээлэл зэргийг ойлгоно.

! Анхаарах зүйлс:



И-мэйл хаяг: Санал хүсэлт, өргөдөл гомдол, мэдээлэл хүлээн авах имэйл хаяг нь сургуулийн ажлын хэрэгцээнд ашиглагддаггүй, тусдаа хаяг байна.



Дуудлага хүлээн авах утас: Зөвхөн санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах зорилго бүхий тусгайлсан 1 дугаар байна. Энэхүү утас нь ажлын цагаар ажиллана. Сургуулийн нийгмийн ажилтны хувийн гар утасны дугаар, сургуулийн жижүүр болон аль нэг ажилтны өрөөний утасны дугаар байж болохгүй.



Саналын хайрцаг: Саналын хайрцгийн дотор тал нь харагддаггүй, бат бөх материалтай, хялбар онгойхгүй цоожтой байхаас гадна бичиг хийх зориулалтын хэсэг нь гаднаас дэгээдэж авах боломжгүй байдлаар хийгдсэн байна. Хайрцгийг камергүй газар, бага насны хүүхэд болон тэргэнцэртэй хүүхдийн нуруу хүрэхүйц өндөрт, хананд бэхлэн байрлуулна. Саналын хайрцаг дээр QR код байрлуулж, түүгээр дамжуулан мэдээлэл авч болно.



Албан, албан бус нүүр тулсан уулзалтаар мэдээлэл өгөх: Энэ тохиолдолд мэдээллийг хүлээж авах өрөө нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмчийн уулзалтын өрөөний стандарт хангасан байх нь тохиромжтой. Өрөөний хаягийг хүүхдийн нурууны өндөр болон ялгаатай байдалд тохируулан байрлуулах ба ажилтны чиг үүргийн талаар дэлгэрэнгүй танилцуулгатай байна. Тухайн ажилтан хагас өдрөөс илүү хугацаанд сургуулиас өөр газар ажиллах, сургалтад хамрагдах, өвдөх, чөлөө, амралт авах зэргээр эзгүй байх тохиолдолд эзгүй байх хугацаа, өөрийг нь орлон ажиллах хүний нэр, хаягийг хаалган дээр тодорхой бичнэ.

3. Мэдээллийг хэн хүлээж авах вэ?

Эдгээр сувгуудад ирсэн мэдээллийг шалгах эрхтэй 3 ажилтан байх нь тохиромжтой. Тухайн сургуулийн захирал Хүүхэд хамгааллын багийн 2 гишүүн, Ёс зүйн хорооны 1 гишүүнийг тодорхой хугацаатай томилж, тушаал гарган албажуулна.

Томилогдсон баг нь и-мэйл хаяг, цахим хуудас, пейж хуудасны нууц үг болон саналын хайрцгийн түлхүүрийг хадгалж, шалгах ба амрах, чөлөө авах, өвдөх, томилолтоор явах зэрэг тохиолдолд бие биеэ нөхөж, ажил үүргээ хуваан гүйцэтгэнэ.



Мэдээлэл хүлээн авах багийн гишүүдийн үүрэг:

- Мэдээллийн сувгуудыг цаг тухайд нь шалгах
- Ирсэн мэдээллийг хүлээн авч бүртгэж, ангилах
- Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэлтээс өөр мэдээллийг сургуулийн харьяалах өөр алба, эсвэл мэргэжлийн бусад байгууллагад шилжүүлэх
- Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой мэдээллийг сургуулийн Хүүхэд хамгааллын багийн ахлагчид 24 цагийн дотор мэдэгдэх
- Ирсэн мэдээллийн хариуг ажлын 3-5 хоногийн дотор мэдээлэл ирүүлсэн хүнд өгөх, мэдээллийг сургуулийн өөр багт шилжүүлсэн бол тухайн баг хариуг өгч байгаа эсэхэд хяналт тавих
- Энэ үлгэрчилсэн загварын 2.8-д тусгагдсан “Мэдээлэл хүлээн авах багийн гишүүдийн мөрдөх Ёс зүйн дүрэм”-ийг баримтлах
- Ирсэн мэдээллийн агуулга болон шийдвэрлэсэн байдлын товч тайланг сар болгон сургуулийн мэдээллийн самбарт тавина. Ингэхдээ мэдээллийг дэлгэрэнгүй дурдахгүй, ялангуяа хүүхдийн болон хувийн мэдээллийг бичихгүй бөгөөд сард хэдэн санал хүсэлт, өргөдөл гомдол ирснээс хэд нь бүрэн шийдвэрлэгдсэн, хэд нь шийдвэрлэх шатандаа байгаа зэргийг ерөнхий байдлаар бичнэ.

**Санамж:**

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэлтийн мэдээлэл их ирнэ гэдэг нь тухайн сургууль хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайн явуулж байгаагийн илрэл байж болно. Мөн нөгөө талаас хүүхдийн эрхийн зөрчил, хамгааллын асуудлуудыг цаг алдалгүй, мэргэжлийн түвшинд анхаарч ажиллахыг сануулж байж болно. Харин мэдээлэл ирэхгүй байх нь асуудал байхгүй гэсэн үг биш, харин эрт илрүүлэлт сул байгааг харуулж байж болзошгүй.

4. Ирсэн мэдээллийг хэрхэн зохион байгуулах вэ?Мэдээлэл хүлээн авах сувгуудыг шалгах:

- И-мэйл хаяг, пэйж хуудасны чатыг өдөр бүр шалгаж, бүртгэнэ.
- Саналын хайрцгийг өдөр бүр шалгана. Магадгүй шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай мэдээлэл ирсэн байж болзошгүй тул 2-3 хүн хамт нээнэ.
- Шуурхай тусламжийн үйлчилгээ шаардлагатай мэдээллээс бусад санал хүсэлт, өргөдөл гомдлын хариуг ажлын 3-5 хоногт багтаан өгнө.

Мэдээллийг бүртгэж, ангилах:

- Ирсэн мэдээлэл бүрийг бүртгэнэ. Ингэхдээ үнэн эсэхийг батлахыг мэдээлэгчээс шаардахгүй.
- Мэдээллийг “Мэргэжлийн байгууллагад холбон зуучлах мэдээлэл”, “Сургууль дотооддоо шийдвэрлэж болох хүүхэд хамгааллын мэдээлэл” “Бусад” гэж 3 ангилна.
 - **Мэргэжлийн байгууллагад холбон зуучлах мэдээлэл:** хүүхэд хүчирхийллийн улмаас гэмтэж бэртсэн, эсвэл аюултай нөхцөл байдалд байгаа, хонох газаргүй болсон зэрэг яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагууд буюу эрүүл мэнд, цагдаа, хамтарсан багийн үйлчилгээ, хүүхдийн тусламжийн утас 108 зэрэгт нэн даруй холбон зуучилж, хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлнэ.
 - **Сургуулийн зүгээс зарим арга хэмжээг авч болох хүүхэд хамгааллын мэдээлэл:** сургууль, дотуур байрын дүрэм журам зөрчсөн, хүүхдийг үл хайхрах болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртүүлсэн эцэг эх, асран хамгаалагчийг хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын сургалт, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны ганцаарчилсан уулзалт зөвлөгөөнд хамруулах, үе тэнгийн дээрэлхэл, төрөл бүрийн зөрчил, маргаан гарсан тохиолдолд тухай бүр шийдвэрлэх, шинэ багш, ажилтнууд болон шинэ сурагчдын сургуулийн орчин, ангид дасан зохицол зэргийг ойлгоно.
 - **Бусад:** сургууль, дотуур байрын орчны тохижилт, хичээлийн агуулга, сурах бичиг, багш, ажилтнуудын заах арга барил, харилцаа, хандлагын тухай болон бусад асуудлуудыг ойлгоно.

**Санамж:**

Ирсэн мэдээлэл нь сургуулийн Хүүхэд хамгааллын багийн аль нэг гишүүнтэй холбоотой бол мэдээлэл хүлээн авах багийн мөрдөх Гишүүдийн ёс зүйн дүрмийн дагуу мэдээллийг хамгийн түрүүнд Хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаа, Хамтарсан баг, аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, эсвэл Боловсролын хэлтэст өгнө.

2 Мэдээлэл шилжүүлэх үйл явц

1. Мэргэжлийн байгууллага руу холбон зуучлах
2. Мэдээллийг дотооддоо шилжүүлэх
3. Эрсдэлийн болон Нөхцөл байдлын үнэлгээ хийх

Хоёрдугаар шат. Мэдээлэл шилжүүлэх үйл явц

1. Мэргэжлийн байгууллага руу холбон зуучлах

- Мэдээлэл хүлээн авах баг нь ирсэн мэдээллийг ангилж, хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан эсвэл учруулахуйц бол цаг алдалгүй хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээнд холбон зуучилна.
- Сургуулийн Хүүхэд хамгааллын баг нь хүүхдийг холбон зуучлахдаа түүнд болон гэр бүлд нь үйлчилгээний талаар тайлбарлаж, таниулсан зөвшөөрөл авах ба тэднийг

дагалдан явж, холбон зуучилсан байгууллагын ажилтантай уулзуулан, цаашид ямар үйлчилгээг тэндээс авах талаар нь тайлбарлаж өгнө. Холбон зуучлах үйлчилгээ нь үүгээр зогсохгүй ба үйлчилгээний үр дүнд хяналт тавьж, эргэх холбоотой ажиллана. Зарим үйлчилгээг сургууль нь тухайн байгууллагатай хамтарсан төлөвлөгөө гарган үзүүлж болно.

2. Мэдээллийг дотооддоо шилжүүлэх

“Сургуулийн зүгээс зарим арга хэмжээг авч болох хүүхэд хамгааллын мэдээлэл” бол сургуулийн хүүхэд хамгааллын багийн ахлагчид 24 цагийн дотор шилжүүлнэ.

“Бусад” төрлийн мэдээлэл бол сургууль, дотуур байрын орчны тохижилт, багш, ажилтнуудын заах арга барил, харилцаа, хандлага болон бусад асуудлуудын талаар бол тухайн асуудлыг хариуцдаг сургуулийн алба руу нь 24 цагийн дотор шилжүүлнэ.

3. Эрсдэлийн болон Нөхцөл байдлын үнэлгээ хийх

“Сургуулийн зүгээс зарим арга хэмжээг авч болох хүүхэд хамгааллын мэдээлэл”-ийн хүрээнд мэдээллийг хүлээж авсан даруйдаа сургуулийн нийгмийн ажилтан нь хамтарсан багийн нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчтай хамтран эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийхдээ тухайн хүүхдийн ах, эгч, дүү, нэг айлд эсвэл дотуур байранд хамт амьдардаг бусад хүүхдүүд байвал тэдний эрсдэл, нөхцөл байдлыг хамтад нь үнэлнэ.

Шаардлагатай бол нийгмийн ажилтан нь хүүхэд, дотуур байрын багш, анги удирдсан багш, эцэг эхийг (зөрчил үйлдэгч нь эцэг эх нь биш бол) нь оролцуулан хүүхдийн аюулгүй байдлын төлөвлөгөөг гаргана.



Санамж:

Сургуулийн Хүүхэд хамгааллын багийн үүрэг бол хүүхдийн эсрэг хүчирхийлэл хэрхэн үйлдэгдсэнийг шалгаж тогтоох биш, харин өгсөн мэдээлэлд үндэслэн яаралтай, шуурхай арга хэмжээ авах, шийдвэр гаргах, дэмжлэг үзүүлэх явдал юм. Хүчирхийлэл үйлдэгдсэн эс үйлдэгдсэн эсэхийг хийж, дүгнэлт гаргах нь хуулийн байгууллагын үүрэг юм.

3

Мэдээлэлд
арга хэмжээ авах
үйл явц

1. Үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлэх
2. Үйлчилгээг үнэлэх, дахин төлөвлөх
3. Үйлчилгээг дуусгах

Гуравдугаар шат. Мэдээлэлд арга хэмжээ авах үйл явц

1. Үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлэх

- Хамтарсан багийн гишүүдтэй хамтран хийсэн үнэлгээний дүгнэлтийг нийгмийн ажилтан нь сургуулийн захиралд танилцуулж, захирал 24-48 цагийн дотор хүүхэд хамгааллын багийг зарлан хуралдуулна. Тус хурлаар сургууль дээр үзүүлэх хүүхэд хамгааллын хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төлөвлөгөөг гаргана. Гэхдээ шуурхай

тусламжийн үйлчилгээний үед яаралтай шуурхай арга хэмжээ, цаг алдалгүй мэргэжлийн байгууллагууд руу холбон зуучлагдаж, үзүүлэх ёстой.

- Захирал нь үйлчилгээний төлөвлөгөөнд гишүүдийн оролцоо, үүрэг хариуцлагыг жигд хуваарилахад анхаарах ба шаардагдах зардлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.
- Нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын багийн хурлаар гаргасан үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтэд багаа манлайлан, бүх талын оролцоог хангаж ажиллана.
- Сургуулийн захирал нь 7 хоног бүр хүүхэд хамгааллын багийг хуралдуулж, (шаардлагатай нөхцөлд хугацаа харгалзахгүй төлөвлөгөөт бус хурал хуралдуулна) төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулна. Хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа багийн гишүүдийн бусад ажлын ачааллыг хөнгөвчлөх боломжоор хангана.
- Сургуулийн Хүүхэд хамгааллын баг нь үүссэн асуудал дээр ажиллах арга зүй дутвал аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын хэлтсээс (цаашид ХГБХХХ гэх) дэмжлэг авч болно.

Кейс 1:

Нэгэн сургуулийн 15 настай 2 хүүхэд зодолдож, нэгнийхээ хамрыг хугалсан байна. Тэр даруй захирал, сургуулийн нийгмийн ажилтан нар хүүхдүүдийн эцэг эхийг дуудаж, хамар нь хугарсан хүүхдийн эмчилгээний зардлыг төлөөд, энэ асуудлыг газар авхуулалгүй шийдвэрлэхийг санал болгожээ. Хоёр талын эцэг эх зөвшөөрч, зодсон хүүхдийн ар гэр зодуулсан хүүхдийн эмчилгээний зардлыг төлснөөр энэ асуудал дуусжээ. Хоёр хүүхдэд чиглэсэн нийгмийн ажлын болон сэтгэлзүйн ямар нэгэн үйлчилгээ хийгдээгүй байна.

Зодуулсан хүүхэд хэдэн сар эмчилгээ хийлгэсний дараа эмчлэгч эмч нь “3 жилийн дараа хамрын хагалгаанд орох шаардлагатай болно” гэдгийг эцэг эхэд нь хэлэв. Гэвч тэр үед зодсон хүүхдийн ар гэрээс эмчилгээний төлбөрийг авах боломжгүй. Учир нь нэгдүгээрт, энэ асуудал хаагдсан, хоёрдугаарт, зодуулсан хүүхдийн ар гэр тухайн үед Шүүх эмнэлэгт хандаагүй, хандах ёстой гэдгийг мэдээгүй байна.

Асуулт: Энэ тохиолдолд захирал, сургуулийн нийгмийн ажилтан (СНА) хоёр зөв ажилласан уу?

Алдаа	Сургуулийн хийх алхам
Хэдийгээр хүүхдүүд хоорондоо зодолдсон ч нэгнийхээ биед хохирол учруулсан тул Эрүүгийн хууль ¹ зөрчсөн байна.	Шүүх цагдаа, Хамтарсан багт мэдээлж, хуулийн хүрээнд асуудлыг шийдүүлнэ.

1 Эрүүгийн хууль, 11-р бүлэг, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”

СНА, Захирал нар хоёр хүүхдийн ар гэрийг дуудаж, асуудлыг шийдвэрлэх ёсгүй. Тэдэнд дээр дурдсанчлан - эцэг эхчүүдэд “төлбөр барагдуулах” болон бусад асуудлыг шийдэх аргыг санал болгох - буруутай талыг тогтоох - асуудлыг дуусгавар болгох шийдвэр гаргах эрх болон үүрэг аль ч хуулийн хүрээнд байхгүй.	Хохирсон талд Шүүх эмнэлэгт хандаж, хохирлоо тодорхойлуулах, хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдах, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах талаар мэдээлэл өгнө.
Зодолдсон хоёр хүүхдэд чиглэсэн нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлээгүй.	Зодолдсон хүүхдүүдэд чиглэсэн алдаагаа ухамсарлах, цаашид давтахгүй байх, асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэхэд суралцах нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг СНА, сэтгэл зүйч нар шаардлагатай бол мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзүүлнэ.
	Зодуулсан хүүхдэд анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө өгч, тайвшрахад нь тусална.
	Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ бусдад хор хөнөөлгүй байдлаар илэрхийлэх арга техникуудийг нийт хүүхдүүдэд заана.
	Зодолдсон хүүхдүүдийн аль нэгнийх нь ар гэрээс хэн нэгэн сургууль дээр ирж, нөгөө хүүхдийг нь айлган сүрдүүлэх, заналхийлэх зэргээр сэтгэл санааны дарамтад оруулахаас хамгаална.
	Хоёр хүүхдийг хичээлээс нь завсардуулахгүй байхад анхаарч, урт хугацаанд эмчилгээ хийлгэж, хичээлдээ явах боломжгүй болсон тохиолдолд сургалтын менежертэй хамтран зайны сургалт, нөхөн сургалтын аль тохирсон хувилбараар төлөвлөгөө гарган, ар гэртэй нь хамтран зохион байгуулна.
Зөвлөмж Ийм тохиолдол сургуулиудад түгээмэл гардаг бөгөөд ихэнхдээ дээрхийн ижил шийдэгдсээр байна. Гэвч сургууль дур мэдэн, гэм буруу болон хохирлыг тогтоож, асуудлыг шийдэх шийдвэр гаргаж болохгүй. Хэн нэгний гэм буруу, түүнд оногдох хариуцлагыг зөвхөн шүүх тогтооно. Тиймээс цаашид сургууль өөрийн хууль ёсны эрх, үүргийн хязгаарыг мэдэж, аливаа Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар заагдсан гэмт хэрэг, зөрчлийн асуудлыг шууд эрх бүхий байгууллагад (цагдаа, хамтарсан баг гэх мэт) шилжүүлж, шийдвэрлэгдэх явцад дэмжлэг үзүүлнэ. Харин хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч¹ хүүхдүүдийг нийгэмшүүлэх, сургууль, дотуур байрын орчинд нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сурч боловсрох эрхийг нь хангах, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний чиглэлээ барин ажиллах нь зүйтэй.	

1 Нэр томьёоны тайлбар хэсгээс харна уу.

2. Үйлчилгээг үнэлэх

Сургуулийн Хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүд хангагдсан эсэхэд явцын болон эцсийн үнэлгээг хийж, үйлчилгээг дүгнэнэ.

Үйлчилгээг үнэлэхдээ сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар дараах аргуудыг ашиглаж болно¹. Үүнд:

- Хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах;
- Багийн гишүүдийн саналыг сонсох;
- Тухайн хүүхдийн анги удирдсан багшийн хүүхдэд гарч буй өөрчлөлтүүдийн талаарх ажиглалт, үзэл бодлыг сонсох;
- Хамтарч ажилласан байгууллагын ажилтнуудын саналыг сонсох.

Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар үнэлгээний дүгнэлтээ сургуулийн хүүхэд хамгааллын багт танилцуулахаас гадна үнэлгээний дүгнэлтийг цаашдын үйлчилгээнийхээ үр дүн, чанарыг сайжруулахад ашиглана.

3. Үйлчилгээг хаах

Сургуулийн Хүүхэд хамгааллын баг дээрх мэдээллийн 3 үйл явцын зааврын дагуу үйлчилгээг хүргэж, цаашид сургуулийн СНА болон Хамтарсан баг хүүхэд хамгааллын асуудлаар кейс нээж ажилласан бол дараах тохиолдолд кейсийг хааж, үйлчилгээг дуусгана. Үүнд:


1. Хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ зорилгодоо хүрсэн, хүүхэд аюул, хөнөөлгүй орчинд сурч, амьдрах болсон, сайн сайхан байдал нь хангагдсан;
2. Хүүхэд, гэр бүл өөр орон нутагт албан ёсоор шилжиж, өөр байгууллага, хөтөлбөрт хамрагдах болсон;
3. Хүүхэд нас барсан;
4. Хүүхэд 18 нас хүрч, сургуулиа төгссөн.


Үйлчилгээг хаахдаа нийгмийн ажилтан үйлчилгээг хаах тэмдэглэл бичиж, хүүхэд, гэр бүлд танилцуулна.

Хэдийгээр үйлчилгээг хаасан ч хүүхдийн аюулгүй байдлыг анхаарч, дахин эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, ажиглалтаа үргэлжлүүлнэ.

¹ Дэлгэрэнгүйг Хүүхдийг Ивээх Сан "Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн гарын авлага" 2020 он номоос үзнэ үү. https://savethechildren.mn/?page_id=12120&lang=mn

Бүдүүвч 1





ЕБС-ийн хүүхэд хамгааллын ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД-ийн чиг үүргийн хүрээ

Сургуулийн захирал, Сургалтын менежер, Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч, Анги удирдсан болон бусад багш нар

Шуурхай тусламжийн үйлчилгээ ¹		Хамгаалах, нөхөн сэргээх	Холбон зуучлах	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ ²	Холбон зуучлах	Урьдчилан сэргийлэх	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг эрт илрүүлэх
Аюулгүй байдлыг хангах	Холбон зуучлах	Хамгаалах, нөхөн сэргээх	Холбон зуучлах	Хамгаалах, нөхөн сэргээх	Холбон зуучлах	Урьдчилан сэргийлэх	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг эрт илрүүлэх
Сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хүчирхийлэлд өртсөн, амь нас, эрүүл мэнд нь аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд шууд цагдаад мэдэгдэнэ.	Эмнэлэг, цагдаа, Хамтарсан багт хүүхдийн асуудлыг холбон зуучилна.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний явцад эрүүл мэнд, хууль эрх зүй, нийгмийн халамж, боловсрол, сэтгэл зүйн дараагийн шатлалын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучилж болно.	Энэ үлгэрчилсэн загварын 2.1 дэх "Сургууль, дотуур байрын удирдлага, багш ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг"-т дурдагдсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Аливаа эрсдэлийг эрт илрүүлэхэд тухайн ажилтны хүүхдийг хайрлах хүнлэг сэтгэл, чин сэтгэлийн анзаарга, нямбай ажиллагаа нэн тэргүүнд хэрэгтэй бөгөөд дараах аргууд үр дүнтэй байдаг.
Цагдаа ирэх хүртэл хүүхдийг аюулгүй өрөө ⁴ -нд түр байрлуулж, хэрэв хүүхэд бэртсэн бол сургуулийн эмч нь эмнэлгийн анхны тусламж үзүүлнэ ⁵ . Үүнтэй зэрэгцэн сэтгэл зүйч нь сэтгэл зүйн анхны тусламж үзүүлж, тайвшруулах арга хэмжээ авна.	Хэрэв үйл явдлыг харсан, сонссон хүүхдүүд сэтгэл зүйн хүчтэй цочрол авсан бол харьяа аймаг, дүүргийн ХГБХХХ-т хандаж, мэргэжлийн нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээнд 24 цагийн дотор холбон зуучилна.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний явцад эрүүл мэнд, хууль эрх зүй, нийгмийн халамж, боловсрол, сэтгэл зүйн дараагийн шатлалын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучилж болно.	Энэ үлгэрчилсэн загварын 2.1 дэх "Сургууль, дотуур байрын удирдлага, багш ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг"-т дурдагдсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Аливаа эрсдэлийг эрт илрүүлэхэд тухайн ажилтны хүүхдийг хайрлах хүнлэг сэтгэл, чин сэтгэлийн анзаарга, нямбай ажиллагаа нэн тэргүүнд хэрэгтэй бөгөөд дараах аргууд үр дүнтэй байдаг.
Нийгмийн ажилтан нь хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид болсон үйл явдлын мэдээллийг хүргэх ба Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, журмыг (цаашид ХАБХБЖ гэх) мөрдөнө. Хэрэв хүүхэд эцэг эх, асран хамгаалагчийнхаа зүгээс хүчирхийлэлд өртсөн бол шууд Хамтарсан баг руу мэдэгдэнэ.	Хэрэв хүүхэд гэмт хэргийн оролцогч бол аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд холбон зуучилна.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хүүхэд урт, богино хугацаанд гэртээ болон эмнэлэгт эмчлүүлэх, түр хамгаалах байранд байрлах, түр саатуулагдах, мэдүүлэг өгөх зэргээр хичээлдээ явж чадахгүй нөхцөл тулгарвал сургалтын менежер, анги удирдсан багш нь хүүхдэд сэтгэцийн гэмтэл дахин учрахаас урьдчилан сэргийлэх, илаарьшуулах, хичээлээс хоцрогдох, сургууль завсардахаас сэргийлж, сургалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллана.	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний явцад эрүүл мэнд, хууль эрх зүй, нийгмийн халамж, боловсрол, сэтгэл зүйн дараагийн шатлалын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучилж болно.	Энэ үлгэрчилсэн загварын 2.1 дэх "Сургууль, дотуур байрын удирдлага, багш ажилтнуудын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг"-т дурдагдсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Аливаа эрсдэлийг эрт илрүүлэхэд тухайн ажилтны хүүхдийг хайрлах хүнлэг сэтгэл, чин сэтгэлийн анзаарга, нямбай ажиллагаа нэн тэргүүнд хэрэгтэй бөгөөд дараах аргууд үр дүнтэй байдаг.
						Тус хэсэгт сургуулийн ажилтан бүрийн ажлын байрандаа хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах үүргийг нарийвчлан тусгасан болно.	Хүүхэдтэй шууд болон шууд бусаар харилцаж байгаа багш, ажилтнууд гэмтэж бэртсэн, дуугаа хурааж, бусадтайгаа харилцахгүй байгаа, эсвэл түрэмгий, дээрэлхүү харилцдаг, хичээлээс байнга хоцорч, тасалдаг, улиралдаа тохирохгүй хувцасладаг гэх мэт болон бусад байдлаар харагдах байдлаасаа анхаарал татаж байгаа хүүхдүүдийг ажигласан бол сургуулийн ХХБ-т мэдээлнэ.

1 Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 4.2 дугаар зүйл
2 Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 4.3 дугаар зүйл
3 Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 4.9 дугаар зүйл
4 Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч, эмчийн өрөө нь шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглах нөөцөөр хангагдсан байна.
5 Сургууль хүүхэд хамгааллын төсөвт хүүхэд хамгааллын шуурхай тусламж үйлчилгээний төсвийг тусгасан байна.
6 Ажиллалт хийх нь тухайн ажиглаж буй хүн өөрийн сэтгэл хөдлөл, сэжиг таамагаар дүгнэлт хийлгүй, тухайн цаг мөчид болж буй үйл явцыг яг байгаагаар нь шууд хүлээн авахыг хэлнэ.

Хэрэв хүүхэд гэр бүлдээ болон сургуулиас гадуур орчинд хүчирхийлэлд өртөж, гэмтэж бэртсэн нь сургууль дээр илэрсэн тохиолдолд дээрхийн ижил арга хэмжээ авна.	Сургууль нь хүүхдийн асуудлыг аль ч байгууллагад холбон зуучилсан, тухайн хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавина. Хэрэв хангалтгүй гэж үзвэл тухайн байгууллагад өргөдөл, гомдол гаргаж, хүүхдийн асуудлыг шийдэгдэх хүртэл анхаарал тавьж ажиллана.	Нийгмийн ажилтан нь эцэг эх, асран хамгаалагчийг хүүхэд хүмүүжүүлэх зэрэг аргын сургалтад хамруулж, зөвлөгөө өгнө. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсны дараа сургуульдаа эргэн ирж буй хүүхдэд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулж, ХХБ-ийн гишүүд хамтран хэрэгжүүлнэ. Сургуулийн захирал, сургалтын менежер нь хүүхдийн хичээл хоцрогдол нөхөж нэмэлт цагаар ажилласан багш нарын илүү цагийн ажлын хөлс болон нийгмийн ажлын үйлчилгээний зардлыг журмын дагуу цаг алдалгүй шийдвэрлэж өгнө.	Хүүхдийг ямарваа нэгэн урлагийн үзүүлбэр, арга хэмжээнд оролцуулахдаа хүүхдийн дээд эрх ашиг, аюулгүй байдлыг нэн тэргүүнд анхаарна.	Анги удирдсан болон хичээл зааж буй бусад багш нар хичээлийн явцад хүүхдийн зан авирын огцом өөрчлөлт ажиглагдвал сэтгэл зүйч, нийгмийн ажилтанд мэдээлнэ. <u>Асуумж авах</u> Сэтгэл зүйч, Нийгмийн ажилтан нь хүүхдийн дунд хүчирхийллийн эрсдэл илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд хэвийн байгаа эсэхийг шатлалтайгаар илрүүлэх асуумж явуулан анхаарах шаардлагатай хариулт ирүүлсэн хүүхдүүдийг илрүүлнэ. <u>Албан ба албан бус нүүр тулсан уулзалт хийх</u> Асуумж, ажиглалтаар илэрсэн, өөрөө болон бусдаар дамжуулан хандсан хүүхдүүдийг ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, зөвлөгөө, сургалтад хамруулан эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж болно.
---	--	---	--	--

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд сургуулийн зүгээс ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧДАД өгч болох жишиг зөвлөмж

Шуурхай тусламжийн үйлчилгээ		Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх үйлчилгээ	
Аюулгүй байдлыг хангах	Холбон зуучлах	Хамгаалах, нөхөн сэргээх	Урьдчилан сэргийлэх	Эрт илрүүлэх
Хүүхэд хүчирхийлэлд өртөх, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд шууд Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол-102, Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл -107, Эмнэлгийн түргэн тусламж 103, Гамшиг, осол, аврах ажиллагаа-105, Хүүхдийн тусламжийн утас-108 зэрэг шуурхай тусламжийн утсанд залгах буюу 102,108 утсанд мессеж илгээх боломжтой.	Таны болон бусдын хүүхэд хүчирхийлэлд өртөх, эрсдэлд орох тохиолдолд яаралтай Цагдаа, эмнэлэг, Хамтарсан баг ¹ -т мэдээлнэ.	Хүүхдэд “Чи ганцаараа биш. Бид хамт байна” гэдгийг үргэлж хэлж, түүнд аюулгүй мэдрэмж өгч, үүнийг бататгаж байна. Хүүхдээ анхааралтай сонсож, ойлгож, дэмжиж, үргэлж хүлээцтэй хандана. Түүнд хайртай хэвээрээ, түүнд итгэдэг гэдгээ үг хэл, үйлдлээрээ илэрхийлнэ. Хүүхдээ мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд хамрагдах боломжийг хангаж өгнө.	Амьдарч буй орчиндоо эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг цаг алдалгүй арилгана. Хүүхэд өөрийгөө сорих, турших зорилгоор эрсдэлтэй үйлдэл хийхээс хамгаалж, үр дагаврын талаар сайтар хэлж ойлгуулдаг байна. Хүүхэдтэйгээ харилцах, тэднийг хүмүүжүүлэх эерэг аргуудын талаар судалж, суралцаж өөрийгөө байнга хөгжүүлж байна.	Хүүхдийнхээ зан байдалд гарч буй өөрчлөлтөд соргог хандаж, ямар нэг асуудал гарсан эсэхийг нягтална. Хүүхдийнхээ найзуудын талаар сайн мэддэг байх, чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж байгааг нь анхаарал тавина.
Тусламж ирэх хүртэл хүүхдийг аюулгүй газар түр байрлуулна.	Хэрэв хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцогч хүүхэд ² бол аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон Хүүхдийн эрхийн Улсын байцаагчид хандаж болно.	Хүүхдийн үйлчилгээ авч буй мэргэжлийн байгууллагуудын өгсөн зөвлөгөөг сайтар баримталж, хэрэгжүүлнэ. Асуудлыг болон хүнд хэцүү зүйлийг даван туулж яваа хүүхэд бие махбод, сэтгэл хөдлөл, нийгэм, ёс суртахууны хувьд мэдрэмжээ илэрхийлэхийг нь дэмжиж, зарим тохиолдолд сөрөг зан үйл үзүүлэхэд тэвчээртэй хандаж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө авч, нөхцөл байдлыг хамтдаа даван туулна.	Эцэг эх гэдэг давуу байдлаа ашиглаж, хүүхдийн нэр төр, бие махбод, амь нас, эрүүл мэндэд хор хохирол учруулахгүй. Бага насны хүүхдийг гэрт нь ганцааранг нь үлдээх, хараа хяналт сул газар руу явуулах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, зүй бус үг хэллэг хэрэглэх, зохисгүй байдлаар биеэ авч явахгүй байна. Хичээлийн бус цагаар оролцож буй хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаа нь хүүхдийн аюулгүй байдлыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай бол санал өгнө.	Хүүхэдтэйгээ ярилцахдаа анхааралтай сонсож, тодруулах шаардлагатай яриа гарсан тохиолдолд заавал шалтгааныг нь олно. Түүний яриа, асуултад ач холбогдол өгч, заавал хариулдаг, юу гэж бодож байгаагаа тодорхой илэрхийлдэг байна.

1. Нэр томьёоны тайлбар хэсгээс харна уу.

2. Нэр томьёоны тайлбар хэсгээс харна уу.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд сургуулийн зүгээс ХҮҮХДЭД өгч болох жишиг зөвлөмж

Шуурхай тусламжийн үйлчилгээ		Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх үйлчилгээ	
Аюулгүй байдлыг хангах	Холбон зуучлах		Урьдчилан сэргийлэх	Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг эрт илрүүлэх
Хүүхэд бусдын аюулгүй байдлыг хангах явцдаа өөрийгөө эрсдэлд оруулж болзошгүй тул хүүхдэд өөрийнхөө болон бусдын аюулгүй байдлыг хангах хариуцлагыг хүлээлгэж болохгүй.	Хүнд хэцүү нөхцөл байдалд орсон найз нөхөд, үе тэнгийнхнээ талаар сургуулийн ХХБ, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, ангийн багш, бусад багш, эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэнэ.	Хүнд хэцүү асуудлыг туулж яваа найз нөхөд, үе тэнгийнхнээ анхааралтай сонсох, түүнийг шоолж, гадуурхахгүй байна.	Сургуулийн хүүхэд хамгааллын сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө, дотоод дүрэм, журам гаргахдаа хүүхдийн санал бодлыг сонсож, тусгасан байна.	
Харин хүүхэд өөрөө аюултай нөхцөл байдлын талаар багш, сурган хүмүүжүүлэгч, мэргэжлийн байгууллагын өгсөн зөвлөмжийг баримталж, өөрийнхөө аюулгүй байдлыг хангахад оролцох хэрэгтэй.	Ялангуяа тухайн хүүхдийн болон бусад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай "Хадгалж болохгүй нууц"-ыг заавал задалж, мэргэжлийн байгууллага, үүрэг хүлээсэн ажилтанд мэдээлнэ.	Тухайн хүүхдийн оронд өөрийгөө тавьж бодох, юу туулж явааг нь ойлгохыг хичээж, өрөвдөн энэрэх сэтгэлээр хандана.	Сургууль, багш, ажилтнууд нь хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэгчид юм. Харин хүүхэд-хүүхдэдээ нөлөөлж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж болдог. Гэхдээ хүүхэд бусад хүүхдэдээ нөлөөлөх явцад өөрийгөө эрсдэлд оруулж болзошгүй эсэхийг үүрэг хүлээгчид заавал анхаарна.	
Яаралтай тусламжийн утасны дугаар, харьяа сум, хорооньхоо Хамтарсан багийн гишүүд, тэдний утас болон сургуулийнхаа Хүүхэд хамгааллын багийн гишүүд, утасны дугаарыг нь мэддэг байх хэрэгтэй бөгөөд үүрэг хүлээгчдийн зүгээс танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулна.	Хадгалж болохгүй нууц: Тухайн хүүхэд хүчирхийлэлд өртдөг, дээрэлхүүлдэг, хэн нэгэн түүний биед зөвшөөрөлгүй хүрдэг, өөрийгөө болон бусдыг гэмтээх, амиа хорлох тухай боддог, төлөвлөдөг, тулгарсан асуудлаасаа болоод өдөр тутмын амьдралаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон зэргийг ойлгоно.	Тухайн хүүхэд дахин хүчирхийлэлд өртөх болон өөр таагүй асуудалтай тулгарвал яаралтай сургуулийн ХХБ, сум, хороо, аймаг, дүүргийн хамтарсан багт, сургуулийн нийгмийн ажилтан, ангийн багш зэрэг хүмүүст мэдээлнэ.		
	Мэргэжлийн хүнд мэдээлэл өгөх нь хов ярьж, нууцыг задалж байгаа хэрэг огтхон ч биш. Хэрэгтэй тусламжаа авахын тулд бусдын нууцыг хадгалах үүрэг хүлээсэн мэргэжлийн хүнд хандаж байгаа гэдгийг ойлгох нь чухал.			

1.7. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ ХҮҮХЭД СУРГУУЛЬДАА ЭРГЭН СУРАЛЦАХ, ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХАД АНХААРАХ АСУУДЛУУД

Аливаа гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч, холбогдогч болсон хүүхдүүд асуудлаа шийдэх явцад болон шийдэгдсэний дараа энгийн амьдралаа үргэлжлүүлэх, сургуульдаа эргэн суралцах хэрэгтэй болдог.

Энэ нь тэдний хувьд бусад хүүхдүүд өөрийнх нь тухай мэдсэн байх вий, өөрийг нь шоолж, буруутгаж, гадуурхах вий гэсэн эргэлзээ, айдас төрүүлсэн амаргүй цаг үе юм. Учир нь эдгээр хүүхдүүд өөрийн нас, хүйс, хүмүүжил төлөвшлөөс үл хамааран үнэхээр хүнд хэцүү зүйлийг үзэж туулж байдаг тул тэдний бие махбод, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, нийгэм, ёс суртахууны хөгжилд олон сөрөг нөлөө үзүүлсэн байдаг.

Энэхүү эмзэг цаг үед сургуулийн Хүүхэд хамгааллын баг ялангуяа анги удирдсан багш нар хүүхдийн мэдрэмж, хэрэгцээ, хүсэл, итгэл үнэмшил, харилцааны хэв маягт мэдрэмтгий хандаж, тэднийг ойлгохыг хичээж ажиллах нь зүйтэй тул дараах зүйлсийг анхаарахыг зөвлөж байна. Үүнд:

- **Нууцыг хадгалах:** Нууцлалын асуудал нь зөвхөн хохирогч, гэрч төдийгүй, гэмт хэрэг үйлдсэн, сэжигтэн, яллагдагч хүүхдүүдэд ч хамааралтай. Учир нь тэд хэдийгээр гэм буруутай нь тогтоогдсон ч “хүүхэд”, цаашид урт удаан амьдрах учраас тэднийг хамгаалах учиртай юм.
- **Хүн өөрчлөгддөг, өсөж хөгждөг гэдгийг хүлээн зөвшөөрөх:** Хохирогч хүүхэд насан туршдаа хохирогч болж амьдрахгүй, цагаа олсон зөв дэмжлэг нь тэднийг асуудлаа даван туулж, хугацаа шаардсан ч эргэн хэвийн амьдралд нь оруулж болдог гэдэгт итгэдэг. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн ирээдүй “нэгэнт өнгөрсөн” бус тэднийг буруутгаж шүүлгүй, ойлгон тусалснаар өөрчлөгдөж, зөв төлөвших боломжтой гэдгийг ойлгодог, өөрийнхөө субьектив хандлагыг барьж ажиллаж чаддаг байх хэрэгтэй.
- **Хүүхдийн давуу талыг анхаарах:** Хүүхэдтэй ажиллахдаа дутагдалтай, сул талд нь анхаарч, түүнийг засан сайжруулахад төвлөрөх бус, харин тэднийг өөр өөрийн онцлог давуу тал, чаддаг зүйлтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, тэрхүү чадварыг нь улам өнгөлөн дэмжих нь үр дүнтэй байдаг. Давуу талд суурилсан арга зүй нь хүүхдийн төрөлхийн даван туулах чадвар, сэтгэлийн хатад тулгуурлан түүнийг улам хүчирхэгжүүлэхэд чиглэдэг.
- **Аюулгүй, хамгаалагдсан мэдрэмж өгөх:** Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, анги удирдсан багш нарын хүүхэдтэй харилцаж буй харилцаа бүр нь тэднийг илаарьшуулахад тусалдаг. Өөрийг нь буруутгалгүй, сайн ойлгож, идэвхтэй сонссон уулзалт, ярилцлага бүр хүүхдийн өөртөө болон багшдаа, бусдад, ангийнхандаа итгэх итгэлийг бэхжүүлж, аюулгүй, хамгаалагдсан мэдрэмжийг нэмэгдүүлэх үнэ цэнтэй байдаг.

- **Хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг анхаарах:** Насны хөгжлийн үе шатнаас хамааран хүчирхийллийн улмаас гарах өөрчлөлт өөр байдаг. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээний хэрэгцээг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хамрагдсан байдлаар тодорхойлно. Учир нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд сэтгэл зүйн гэмтлийн улмаас мэдрэмж, айдсаа илэрхийлж чадахгүй болсон байдаг. Иймээс хохирогч хүүхэдтэй ажиллаж буй анги удирдсан багш бусад мэргэжилтнүүд тэдэнтэй тайван, итгэлтэй байдлаар харилцахаас гадна үйл хөдлөлөө зөөлөн аядуу байлгах зэрэг тэвчээртэй хандахыг шаарддаг бөгөөд асуудал ажиглагдсан тухай бүр нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй уулзаж, зөвлөгөө авч ажиллана.
- **Харилцаа холбооны үнэ цэнийг ойлгох:** Хүүхэд ангийн багшдаа болсон явдлын тухай, эсвэл өөрийнхөө мэдрэмжийн талаар илэрхийлэхийг хүсвэл сэтгэлээ онгойтол ярихад нь тусалж, ярихыг хүсэхгүй байвал тайван орхих хэрэгтэй. Хүүхдийн илэрхийлж буй мэдрэмж (уурлах, айх, гуниглах гэх мэт)-ийг ойлгож байгаагаа, түүнд итгэж байгаагаа, түүний туулсан зүйл, гаргасан шийдвэрийн зөв бурууг шүүхгүй гэдгээ хүүхдэд ойлгуулна.
- **Хүүхдийн идэвхтэй оролцоог дэмжих:** Хүүхэд хичээлийн бус цагаар өөртөө таалагдсан ямар нэг зүйл хийхэд нь туслах, мэдрэмжээ илэрхийлэх, сатаарах, стрессээ тайлах, өөрийн давуу талаа нээж илрүүлэх зэрэг үйл ажиллагаануудад оролцоход нь чиглүүлж дэмжлэг үзүүлж, урам зориг өгнө.
- **Гэр бүлд нь нөлөөлөх:** Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нартай хамтран эцэг эх, асран хамгаалагч, найз нөхөдтэй нь ярилцах, эргэж хэвийн амьдралдаа ороход нь хэрхэн дэмжих талаар тайлбарлан ойлгуулах тогтмол уулзалтуудыг хийж болно.
- **Гэрийн эргэлт хийх:** Зарим тохиолдолд сургууль, Хамтарсан багийн нийгмийн ажилтантай хамтран гэрийн эргэлтийг хийж болно. Учир нь ихэнх гэр бүлийн гишүүд хүүхдийнхээ анги удирдсан багшийг хүндэлдэг, үгийг нь сонсдог, чөлөөтэй харилцаж чаддаг, илүү итгэдэг байна. Гэрийн эргэлт хийснээр хүүхэд гэр бүлдээ аюулгүй амьдрахад туслах хэрэгцээт үйлчилгээг тодорхойлох, гэр бүлдээ хэрхэн амьдарч байгаа нөхцөл байдлыг том зургаар нь харах, тухайн хүүхэд, гэр бүлийн давуу тал эсхүл асуудлыг нарийвчлан илрүүлэх, гэр бүлтэй итгэлцэл бий болгох давуу талуудтай.
- **Өөрийгөө хөгжүүлэх:** Хүүхэдтэй ажиллахад тулгарсан асуудлуудаа шийдвэрлэх, зохицуулах, харилцах, шийдвэр гаргах ур чадвараа хөгжүүлэх зөвлөгөө, сургалтыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс авч, өөрийнхөө хүүхэдтэй харилцах ур чадварыг сайжруулахад анхаарна.

Анги хамт олон нь тухайн хүүхдийн асуудлыг мэдсэн тохиолдолд анги удирдсан багшийн зүгээс авах арга хэмжээ:

- **Хүүхдийн туулсан зүйлийг хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлэх:** Тухайн хүүхдийн холбогдсон үйлдлийн сайн муу, буруу зөвийг шүүн хэлэлцэхгүй. Харин хэнд ч, хэзээ ч асуудал тохиолдож болдог бөгөөд түүнийг даван туулахад хүмүүс бие биедээ туслах ёстой гэдгийг хүүхдүүдэд нас, хөгжлийн онцлогт тохируулан ойлгуулна. Ингэхдээ нууцыг нь хадгална гэдгээ ямагт санана.

- **Тухайн хүүхдийн давуу талыг харуулах хамт олны үйл ажиллагааг зохион байгуулах:** Хүүхдийг бусад хүүхдүүдэд өөрийн давуу талаа харуулах, хүүхдүүдтэй харилцах, хамтран ажиллах, өөртөө хариуцлага хүлээхэд урамшуулан дэмжих үйл ажиллагааг зориудаар зохион байгуулна.
- **Сөрөг хандлагыг тэр даруй таслан зогсоох:** Анги дотор нь хүүхдийн тухай хов жив, ил, далд гадуурхал гарч байгаа эсэхийг соргог ажиглаж, мэдсэн даруйд таслан зогсооно. Ингэхдээ шууд хориглож, сөрөг хандлага гаргасан хүүхдүүдийг хатуу шийтгэхийн оронд хүнд хэцүү зүйлийг даван туулж яваа хүүхдийн оронд өөрийгөө тавьж бодон түүнийг ойлгохыг хичээх, энэрэх сэтгэлээр нэгэндээ хандах талаар анги хамт олонд нь нөлөөллийн ажил зохион байгуулна.



Анхаарах зүйлс:

Хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчлийг харсан, сонссон буюу гэрч болсон хүүхдүүд сэтгэл зүйн цочролд орж, айдас түгшүүр мэдэрдэг тул тайвшруулах сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээ авна. Хэрвээ хүчтэй цочрол, сэтгэл зүйн гэмтэл авсан тохиолдолд урт хугацаанд мэргэжлийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах ажлыг сургуулийн ХХБ, хүүхдийн гэр бүлтэй хамтран зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. Жишээлбэл, өндрөөс үсэрч амиа хорлох, зам тээврийн осолд орох, үер ус, гал түймэрт өртөх гэх мэт гэнэтийн байдлаар амиа алдаж буй хүнийг санамсаргүй харах нь дээрх үр дагаварт хүргэж болзошгүй.

1.8. МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ БАГИЙН ГИШҮҮДИЙН МӨРДӨХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдгээ хамгийн түрүүнд танд мэдээлэл (хэлэх, бичгээр, утсаар) өгөх үед таны гаргах хандлага тухайн хүүхэд асуудлыг хууль журмын дагуу цаг алдалгүй шийдвэрлэхэд, эрсдэл багатайгаар даван туулахад шууд нөлөөлнө. Түүний хувь заяаг ч шийдэж болох юм. Таны авсан, эсвэл авч чадаагүй арга хэмжээнээс болж тухайн хүүхэд дахин хохирох, эрсдэлд орох ёсгүй.

Хүүхэд хэн нэгний өөрт нь үзүүлж буй зан байдал, үйлдэл, хандлага, хүчирхийллийн талаар санаа зовж байгаагаа илчилбэл дараах зүйлсийг анхаарна.

ХИЙЖ БОЛНО.	ХИЙЖ БОЛОХГҮЙ.
- Хүүхдүүдийн ихэнх нь хүчирхийллийн талаар хүдлаа ярьдаггүй. Тэдэнд итгэж, туслахыг хүсэж байгаагаа хэлнэ. - Энэ тухайгаа зориг гаргаж хэлсэнд нь түүгээр бахархаж байгаагаа илэрхийлнэ. - Болсон явдал түүний буруу биш гэдгийг тайлбарлана. Хүчирхийлэгч өөрийнхөө үйлдэлд хариуцлага хүлээнэ гэдгийг хэлнэ. - Хүүхдийн хувийн нууцыг хүндэтгэ. Түүнд туслах ажиллагаанд шүүд оролцож байгаа хүмүүсээс бусад хүнд түүний асуудлыг ярихгүй, нууцыг нь хадгална гэдгийг хүүхдэд хэлнэ. - Мэдээллийг Хүүхэд хамгааллын багт тэр даруй дамжуулна. Энэ бол таны үндсэн үүрэг. - Хүүхэд хамгааллын багийн гишүүн, эсвэл өөрийн чинь дотно найз, хамаатан садны талаар гомдол, мэдээлэл ирсэн ч Ёс зүйн дүрмээ сахиж, түүнийг нуун дарагдуулахгүй, мэдээллийн журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ. - Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг нь ихэвчлэн гэрчгүй үйлдэгддэг тул хүүхдэд бурууг өгөх хандлага, үйлдлээс татгалзаж, мөрдлөг хийх, мэдүүлэг авах зэргээр цаг алдалгүй цагдаагийн байгууллагад шууд хандана. - Хүүхдийн асуудлыг сонсож байхдаа түүнийг гомдоосон хүмүүст, болсон явдалд уур чинь хүрч мэднэ. Гэвч хүүхдүүд таныг өөрт нь уурлаж байна гэж буруу ойлгож болзошгүй. Тиймээс биеэ барьж, тайван байна.	“Ийм асуудал зөндөө байдаг. Сүртэй юм биш” гэдэг байр сууринаас хандаж болохгүй. - Мэдээлэл өгч буй хүнтэй олон нийтийн газар асуудлыг нь ярилцахаас зайлсхий. - Уйлах, сандрах, уурлах зэргээр хэт их хариу үйлдэл үзүүлж, сэтгэл хөдлөл харуулахгүй байх. - Тухайн хүүхэдтэй харилцаа муу байсан ч асуудалд нь хувийн хандлагаар хандахгүй. - Ярьж буй бүх зүйлийг нь нэгд нэгэнгүй бичих, зураг авах, бичлэг хийж болохгүй. - Тэдэнд юу хийхийг заах, зөвлөгөө өгөхийг хичээх хэрэггүй. - Аливаа мэдээллийг хүлээн авахдаа хэнд ч тараахгүй, задлахгүй гэсэн амлалтыг өгч болохгүй. Асуудлыг даван туулахад мэргэжлийн хүмүүсийн тусламжийг авах тухайг хүүхдэд тайлбарлаж өгөхөөс гадна тэдгээр хүмүүс нууцлалыг хадгалдаг гэдгийг хэлнэ. - Асуудлын талаар олон хүнд хэлж, яаж шийдэх талаар хэлэлцүүлэхгүй. - Хүүхдийн өмнөөс шийдвэр гаргахгүй. - Ямар ч асуудал байсан хүүхдийг буруутгахгүй. - Хүүхдийг ярихыг шахахгүй, ялангуяа хүчирхийллийн үйлдлийг нэг бүрчлэн тоочиж асуухаас зайлсхийнэ. - Хүүхдийг өгсөн мэдээллээ нотлохыг шаардахгүй. Мэдээллийн мөрөөр мөрдлөг хийхгүй. - Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах эрх нь түүний хамгаалагдах эрхийг хөндөж болохгүй. Өөрөөр хэлбэл хүчирхийллийн асуудлыг хувийн нууцад тооцож, хамгааллын үйлчилгээ авахгүй байж болохгүй.

БҮЛЭГ 2

**СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УДИРДЛАГА,
БАГШ АЖИЛТНУУДЫН ХҮҮХЭД
ХАМГААЛЛЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

2.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УДИРДЛАГА, БАГШ, АЖИЛТНУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Сургууль, дотуур байрын удирдлага, багш, ажилтнууд нь хүүхдэд тулгамдсан асуудлыг эрт илрүүлж, тусламж үзүүлэх, тэдний сайн сайхан байдлыг дэмжих, асуудлыг хурцдаж, гүнзгийрэхээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дараах жагсаалтад хүүхэд хамгааллын эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд албан тушаал тус бүрийн ажлын байран дээрээ авч хэрэгжүүлж болох үйл ажиллагааг оруулав.

Сургуулийн үйлчлэгч



Хэдийгээр таны ажлын үндсэн үүрэг цэвэрлэгээ, ариутгал, цэвэрлэгээ хийх хэдий ч ажиллаж буй газар тань хүүхдийн орчин тул таны сонор сэрэмж, анзаарга, болгоомжтой байдал хүүхдүүдийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулах болно. Та сургууль, дотуур байрын өнцөг булан бүрд хүрч ажиллахдаа хүмүүсийн төдийлөн анзаардаггүй эрсдэлүүдийг илрүүлж, аюулгүй болгоход тусалж чадах чухал ажил эрхэлдэг юм шүү

- Ариун цэврийн өрөөний хогийн саванд тамхины иш зэрэг сэжиг бүхий сэжиг бүхий хог хаягдал (зүү тариур, цустай хөвөн, газны лааз, согтууруулах ундааны шил, лааз, сав, бэлгэвч... гэх мэт) хаясан байвал баримтжуулах зорилгоор зургийг нь авч, нэн даруй ХХБ-т мэдээлнэ.
- Цэвэрлэгээ, үйлчилгээ хийх явцдаа сургуулийн гэрэлтүүлэг муутай хэсгүүд, халтирч унах эрсдэлтэй шал, хаалт, хашилт муутай шат, хурц үзүүртэй хашаа, хайс, бүрээс нь хайлсан цахилгааны утас, масстай залгуур, унтраалга зэрэг хүүхдэд эрсдэл учруулж болзошгүй газруудыг байнга анзаарч, энэ талаар Захиргаа, аж ахуйн ажилтанд мэдэгдэж засварлуулна.
- Сургууль, дотуур байрын ариун цэврийн өрөөний хаалга, цоожны бүрэн бүтэн байдлыг анхаарч, эвдэрч гэмтсэн, гацсан, ажиллахгүй байгаа тохиолдолд Захиргаа, аж ахуйн ажилтанд тэр даруй хэлж засварлуулна.
- Хүүхэдтэй харилцахдаа тэдний насны онцлог, хэрэгцээг ойлгож, эелдэг, нөхөрсөг байдлаар харилцах, цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой анхааруулга хэлэх, шаардлага тавихдаа дээрэнгүй, түрэмгий хандлага гаргахаас зайлсхийнэ.
- Үе тэнгийн дээрэлхэл, хүүхэд хоорондын зөрчилдөөнийг харвал нэн даруй таслан зогсоож, ХХБ-т мэдээлнэ. Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг таамаг төрөх болон мэдээлэл авсан тохиолдолд түүний баталгаатай эсэхийг шалгах гэж цаг алдалгүй шууд ХХБ-т мэдээлнэ.
- Сургуульд нэвтэрсэн гаднын хүнийг ажиглаж, хүүхэдтэй ойртох, сэжиг бүхий үйлдэл гаргавал жижүүрт яаралтай мэдэгдэхийн зэрэгцээ ХХБ-т мэдээлнэ.



Сургууль, дотуур байрын жижүүр, манаач

Та дунджаар нэг ээлждээ 2500 хүүхэд хичээллэдэг сургууль хэмээх онцгой объект руу нэвтэрч буй хүмүүсийг хянах, дэг журам сахиулж, аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээдэг хариуцлагатай алба эрхэлдэг билээ. Үүнээс гадна ажлаа хийх явцдаа хүүхдийн зан байдал, үл хайхрагдаж буй эсэхэд ажиглалт хийж, хүүхэд хамгааллын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ч таны оролцоо чухал гэдгийг санаарай.

1. Сургууль, дотуур байр руу нэвтрэх гэж буй хүн бүрийн зорилго, уулзах хүний нэр, орж гарсан цаг, минуттай нь бүртгэж, “Зочин” гэсэн үнэмлэх өгнө. Зочин нь үнэмлэхийг сургууль, дотуур байранд байх хугацаандаа зүүх ба гарахад нь буцааж авна. Харуул зочныг хаана, юу хийж явааг камераар хянана.
2. Бага ангийн сурагчийг гэрээс нь хүн ирж авахгүй оройтуулах байдал 2 ба түүнээс дээш удаа давтагдвал ХХБ-т мэдэгдэнэ.
1. Өглөө маш эрт ирдэг, сургууль дээр байнга оройтдог, улиралдаа тохироогүй хувцас өмссөн (өвлийн улиралд нимгэн гутал, куртиктэй явах гэх мэт), унтаж амраагүй шинжтэй ирж буй хүүхдүүдийг анзаарч, 2 ба түүнээс дээш удаа давтагдвал СНА-д мэдээлнэ.
2. Ангийн цэвэрлэгээ хийхээр оройн цагаар үлдсэн хүүхдүүдэд хяналт тавих, багш, мэргэжилтэн ба асран хамгаалагчийн төлөөлөл зэрэг насанд хүрсэн хүн хамт байгаа эсэх, хэдэн хүүхэд байгаа, өвлийн улиралд 18.00 цагаас хэтрэлгүй гэр рүүгээ явж байгаа эсэхэд хяналт тавина.
3. Сургууль, дотуур байрын гадаах болон дотор гэрэлтүүлэг, хаалга, цонхны бүрэн бүтэн байдалд хяналт тавина. Эвдэрсэн тохиолдолд нэн даруй Захиргаа, аж ахуйн ажилтанд хэлж, засуулна.
4. Сургуулийн орчинд сэжиг бүхий этгээд эргэлдэх, хичээл тарах үеэр хүүхдүүдийг ажиглах, хоргоох байдал анзаарагдах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй хүн сургуулийн бүсэд байвал нэн даруй цагдаагийн байгууллагад хандахын зэрэгцээ ХХБ-т мэдээлнэ.
5. Ээлж хүлээлцэхдээ тухайн өдөр шинээр үүссэн эрсдэлтэй асуудлууд, түүнийг шийдвэрлэсэн болон шийдвэрлэх шатандаа яваа байдал, дараагийн сургууль, дотуур байрын жижүүр, манаачийн анхаарах шаардлагатай зүйлсийг тэмдэглэсэн тэмдэглэлээ хүлээлцэнэ.
6. Сургуулийн орчимд хүүхдүүд хамгаалалтгүй аваарын шат, хурц үзүүртэй эвдэрсэн хашаа хайс, таглаагүй траншей, ухсан нүх зэргийг сонор соргог байдлаар анзаарч, хяналт тавина.
7. Хүүхдүүд нэгнээ дээрэлхэх, зодолдох эрсдэлтэй газруудыг (сургуулийн арын талбай, сагсны талбай, саравч, модтой хэсэг... гэх мэт) анхааралдаа авч, хяналтын камер суурилуулах, бусад шаардлагатай хэрэгслүүдийг Захиргаа, аж ахуйн албанд хандаж шийдүүлнэ.



Тогооч (сургууль болон дотуур байрын)

Гал тогоо, цайны газар нь сургуулийн эмзэг цэгүүдийн нэг юм. Тогооч нь сургуулийн гал тогоо, эрүүл ахуй, хоолны холбогдох стандартуудыг дагаж мөрдөхөөс гадна хийж буй ажиллагааныхаа хүрээнд хүүхэд хамгааллыг дараах байдлаар анхаарч ажиллахыг зөвлөж байна.

1. Гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгслүүдийн аюулгүй байдлыг тогтмол шалгана. Хоолны танхимд уртасгагч залгуур ашиглахдаа хүүхдийн хөлд тээглэхээс сэргийлж байрлуулах, газар байгаа залгуурын утсанд анхааруулах тэмдэглэгээ хийнэ.
2. Хүүхэд түлэгдэхээс сэргийлж, хэт халдаг аяга, таваг ашиглахаас зайлсхийх, хүүхдийн гар, уруул эсгэх эрсдэл бүхий сэтэрхий аяга шаазан, таваг ашиглахгүй.
3. Хүүхэд хоол идэж чадахгүй бөөлжих, хоолондоо удаа дараа орохгүй байх, хоолны танхимд хүүхдүүд нэгнийхээ хоолыг булаах, дээрэлхэх зорилгоор хоолонд нь хог хийх, зориуд асгах зэргээр идүүлэхгүй байх асуудал гарч байгаа эсэхэд хяналт тавьж, ийм асуудал гарсан тохиолдолд сургуулийн эмч, байрын багш, СНА-д яаралтай мэдэгдэнэ.
4. Хүүхдийг гал тогоонд оруулж хоол бэлтгэхэд түслуулах, зоориноос мах, ногоо зөөлгөх, бусад хүүхдүүдэд өгөх халуун хоол, цайг зөөлгөх зэргээр тэдний эрүүл мэнд, амь насанд эрсдэл учруулж болзошгүй ажиллагаанд ямар ч тохиолдолд оролцуулахаас зайлсхийнэ.
5. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлүүд, түүний шинж тэмдэг, илрэх байдлын талаар мэдлэгтэй байж, өөрөө түүнийг үйлдэхээс ямагт татгалзаж, хүүхэд хүчирхийлэлд өртсөн болохыг мэдсэн, сэжиглэсэн, таамагласан тохиолдолд ХХБ-т шууд мэдээлнэ.



Аж ахуйн албаны ажилтнууд

Захиргаа, аж ахуйн албаны ажилтнууд нь хэдийгээр хүүхэдтэй шууд харилцаж ажилладаггүй ч тэдний аюулгүй, тав тухтай суралцах орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Таны ажилдаа хариуцлагатай хандах хандлага нь хүүхдүүдээс гадна тэнд ажиллаж буй бусад багш, ажилтнуудын амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлдэг юм шүү.

Цахилгаанчин:

1. Сургууль, дотуур байрын гадаах болон дотор гэрэлтүүлэг, цахилгаан хэрэгслүүдэд тогтмол үзлэг шалгалт хийж, доголдол үүссэн, эвдэрсэн тохиолдолд нэн даруй засварлана.
2. Хүүхдэд цахилгаан хэрэгсэлтэй зөв харьцах, цахилгаан гүйдэлд цохиулахаас сэргийлэх, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, цахилгаан хэрэгслийг зөв ашиглаж, эдэлгээг удаашруулах талаар хялбаршуулсан сургалт зохион байгуулна.

Засварчин/слесарь:

1. Цэвэр, бохирын хоолойд тогтмол үзлэг шалгалт хийж, элэгдэж муудсан хэсгүүдийг цаг алдалгүй солино.
2. Хичээл сургалтын үеэр бохирын хоолой задарсан тохиолдолд ойролцоох анги танхимд хичээл сургалтыг үргэлжлүүлэхгүй байхыг сургуулийн ХХБ-т зөвлөх бөгөөд тухайн сургуулийн “Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд оролцоно.
3. Сургуулийн орчимд хүүхдүүд хамгаалалтгүй аваарын шат, хурц үзүүртэй эвдэрсэн хашаа хайс, таглаагүй траншей, үхсэн нүх зэргийг сонор соргог байдлаар анзаарч, хяналт тавина.

Нягтлан/нярав:

1. Сургууль, дотуур байрын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой засвар үйлчилгээний зардлыг хурдан шуурхай шийдвэрлэж өгнө.
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг холбогдох хууль, журмын дагуу цаг алдалгүй шийдвэрлэнэ.

Дотуур байрын багш



Хүүхэд дотуур байранд байх хугацаанд байр нь түүний гэрийг, байрын багш нь түүний эцэг эхийг орлодог гэж ойлгож болно. Хоногийн 24 цагийн турш таны асрамж, хараа хяналтад байгаа хүүхдүүдийн эрүүл ахуй, хоол тэжээл, сэтгэл санаа, ариун цэвэр, бие махбодын аюулгүй байдал, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зэрэг бүхий л асуудлуудыг хангахад танаас асар өндөр анхаарал, хариуцлага, сэтгэл шаарддаг билээ. Доорх хүүхэд хамгааллын чиглэлээр таны хэрэгжүүлж болох ажлуудыг “ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ”, Ерөнхий шаардлага MNS6781 2019 болон дотуур байрын дотоод журамтай хамтатган ашиглах нь илүү үр дүнтэй болохыг зөвлөж байна.

1. Дотуур байранд гаднын хүн нэвтрэхээс, гаднын этгээд хүүхдийг дуудаж гаргахаас сэргийлж, 24 цагийн ээлж бүхий хараа хяналттай байна. Хүүхдийн эцэг эх ирвэл заавал бүртгүүлэх ба хүүхэдтэйгээ хамт хонох, бусад өрөөгөөр орох, хүүхдүүдийн усанд орох өрөөг ашиглах, бусад хүүхдүүдийн эцэг эх, хамаатан садны талаар асууж, ярилцах зэргийг хатуу хориглоно. Энэ талаар хичээлийн жилийн эхэнд эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах гэрээнд тусгаж өгсөн байна.
2. Нийт хүүхдүүддээ аюулгүйн тойрог, биеийн хувийн хэсгүүдийг тайлбарлаж, бусдын хил хязгаарыг давахгүй байх, ямар нэг асуудал гарсан үед багшдаа эсвэл сургуулийн ХХБ-т шүүд хэлэх, шүүд хэлж чадахгүй бол мессеж, чат бичих утасны дугаар, хаягийг хэрхэн ашиглах талаар сайтар зааж өгнө.
3. Бага насны, гэрээсээ ганцаараа амьдарч байгаа болон хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, үл хайхрагдах, бие нь өвдөх, том хүүхдүүдэд дээрэлхүүлэх, ах дүүсээрээ нэг өрөөнд хамт амьдрах, стандартад үл нийцэх байдлаар тохижуулах, хоол хүнс, мөнгөө булаалгахаас урьдчилан сэргийлнэ.

4. Дотуур байрын усанд орох газар, ариун цэврийн өрөөний хаалганы цоож, гэрэлтүүлгийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, бүртгэл хөтөлнө.
5. Баасан гарагт хүүхдийг гэр рүү нь явуулахдаа байрын багш зөвхөн эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулна. Хэрэв хүүхдийг хөрш, хамаатан садан нь авч явах бол байрын багш заавал эцэг эх, асран хамгаалагчтай нь утсаар холбогдон тодруулсны дараа хүүхдийг авч явж буй хүнээр гарын үсэг зуруулна. Тухайн хүн нь заавал насанд хүрсэн байна.
6. Хүүхдийг авч явахаар ирсэн эцэг эх, асран хамгаалагч нь архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байвал хүүхдийг өгч явуулахгүй. Эцэг эх, асран хамгаалагч нь эсэргүүцэж, зөрчилдөөн үүсгэвэл сургуулийн ХХБ эсвэл цагдаад яаралтай мэдэгдэнэ.
7. Амралтын өдрүүдээр гэртээ очоод ням гарагт эргэж ирж хэвшсэн хүүхэд ирэхгүй өвлийн улиралд оройн 16.00 цаг, хавар, намрын улиралд 18.00 цаг хүргэвэл жижүүр багш ар гэр рүү нь утасдаж заавал лавлана. Утсаа авахгүй, холбогдох боломжгүй тохиолдолд Хамтарсан багт мэдээлнэ.
8. Хүүхэд гэртээ хариад ирэхдээ хэт их ядарсан, өлссөн, цангасан байдал 2 ба түүнээс дээш удаа ажиглагдсан, бэртэж гэмтсэн, өвдөж шархалсан эсвэл сэтгэл зүйн хувьд таагүй байдалтай ирсэн тохиолдолд анхаарал тавих, ямар нэг санааг нь зовоосон асуудал байгаа эсэхийг тандаж, ярилцах, хүчирхийллийн сэжиг таамаг илэрвэл сургуулийн ХХБ-т нэн даруй мэдэгдэнэ.
9. Дотуур байранд байрлаж буй ах дүүс, хамаатан саднаараа бүлэг үүсгэж, бусад хүүхдүүдийг дээрэлхэхээс сэргийлэх, байрны дэг журам сахиулах зорилгоор бусдаасаа насаар ахмад, эсвэл биеэр том хүүхдүүдэд давуу байдал олгохгүй.
10. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсны дараа дотуур байрандаа эргэн ирсэн хүүхэд байрныхаа бусад хүүхдүүдэд шоолуулах, гадуурхагдах байдлаар дахин хохирохоос хамгаалж, бусад хүүхдүүдэд зөв ойлголт өгч, сөрөг харилцаа гарахаас урьдчилан сэргийлнэ.
11. Үе тэнгийн дарамт, дээрэлхэл, ялгаварлан гадуурхалт, зүй бус хандлагыг бууруулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршилд автахаас сэргийлэх зорилгоор сургуулийн ХХБ-тай хамтран нийт хүүхдүүдийн дунд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.

Эмч



Хүүхэд хүчирхийлэлд өртөж байж болзошгүй шинж тэмдгийг хамгийн түрүүнд ажиглаж, илрүүлэх боломжтой мэргэжилтний нэг нь эмч юм. Тэр дундаа сургуулийн эмч нь хүүхдийн орчинд ажилладаг учраас хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх төрлүүд, түүний шинж тэмдэг, илрэх байдлын талаар мэдлэгтэй байснаар хүчирхийлэлд өртөж буй хүүхдийг таньж, илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм шүү.

1. Сургуулийн эмч нь ажлын байран дээрээ хүүхэд хамгааллын чиглэлээр дараах үүргийг биелүүлнэ. Үүнд:
 - а. **Таних** – хүчирхийлэл, үл хайхрах, өөрийгөө гэмтээх оролдлого болон бусад хүүхдэд эрсдэлтэй үйлдлүүдийн шинж тэмдгийн талаар тодорхой ойлголттой байх ёстой. Хүүхэд хамгааллын сургалт нь эдгээр шинж тэмдгүүдийг хэрхэн таньж, илрүүлэхэд тусална.
 - б. **Хариу үйлдэл хийх** – хүүхдэд хийж буй үзлэгийн үеэр хүүхэд хүчирхийлэлд өртөж байж болзошгүй гэсэн сэжиг таамаг төрсөн, эсвэл хүчирхийлэлд өртсөн, өртөж байгаа нь тодорхой байвал та зохих арга хэмжээг заавал авах шаардлагатай. Нөхцөл байдлыг үл тоомсорлож болохгүй.
 - в. **Мэдээлэх** – дээрх сэжиг таамаг, санаа зовоосон асуудлуудыг цаг алдалгүй сургуулийн ХХБ-т мэдээлэх шаардлагатай. Нууцлал чухал тул мэдээллийг зөвхөн хүүхдийг хамгаалах үйл явцад оролцох хүмүүстэй хуваалцана.
 - г. **Тэмдэглэл үйлдэх** – үзлэгийн явц, шинж тэмдэг, хүүхдийн биеийн байдал, зовуурь, бие дээрх үл мөрийн талаар дэлгэрэнгүй тэмдэглэл бичиж, зургийг авч хадгална.
 - д. **Холбон зуучлах** – хэрэв хүүхдийн эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд байвал яаралтай дараагийн шатлалын эмнэлэг рүү холбоно.
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдэд давтамжтай үзлэг хийж, дахин хүчирхийлэлд өртөж буй эсэхэд хяналт тавина. Хүүхэд үзлэг хийлгэхээс татгалзвал түүний шийдвэрийг хүндэтгэх ба ХХБ-тай өөр хяналтын арга ашиглах талаар зөвлөлдөж, шийдвэр гаргана.
3. Хүүхдэд хүчирхийлэл, болзооны хүчин, халдварт болон халдварт бус өвчнүүд, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тогтмол сургалт зохион байгуулна.
4. Хүүхэдтэй ярилцлага хийх арга зүйд суралцана. Асуудал тулгарсан хүүхэд хандахад тэднийг сонсоход бэлэн байж, мэргэжлийнхээ хүрээнд зөвлөгөө өгөх үр чадвартай байх нь өдөр тутам ажлын байран дээрээ хүүхдэд туслахад чухал.
5. “ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ”, Ерөнхий шаардлага MNS6781 2019-ын 6.1-р заалт болох Хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээнд заасан чиг үүргийг гүйцэтгэнэ.

Багш (анги удирдсан, гэрээт, дадлагажигч, зочин багш нарыг хамааруулна.)



Багш өөрөө хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэхгүй бөгөөд хүүхэд алдаа дутагдал гаргасан үед шийтгэлийн аргыг хэрэглэхээс ямаг татгалзаж, хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэнэ. Сургууль дээр чинь танд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Хүүхэд хамгааллын баг бий. Нийгмийн ажилтан танд зөвлөгөө, зааварчилгаа өгөх бөгөөд сургалтад хамрагдах боломж олгоно. Таны хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ойлголт тэднийг хамгаалж, аюулгүй байлгахад чухал үүрэг гүйцэтгэх юм шүү.

1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх төрлүүд, түүний шинж тэмдэг, илрэх байдлын талаар мэдлэгтэй байж, өөрөө түүнийг үйлдэхээс ямагт татгалзаж, хүүхэд хүчирхийлэлд өртсөн болохыг мэдсэн, сэжиглэсэн, таамагласан тохиолдолд ХХБ-т шүүд мэдээлнэ.

2. Хүүхэд хичээлдээ ирээгүй, ар гэрээс нь чөлөө аваагүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч руу нь утасдаж шалтгааныг тодруулна. Утсаа аваагүй, холбогдох боломжгүй тохиолдолд ХХБ-т мэдээлнэ.
3. Хүүхдийн хичээл таслалт, хоцролт шалтгаангүйгээр олширох, хүчирхийлэлд өртөж байж болзошгүй шинж тэмдэг илрэх, хичээл дээр унтах, дуугаа хураах, ангийнхнаасаа өөрийгөө тусгаарлах гэх мэт зан үйлийг анхааралтай ажиглаж, хүүхдээс шалтгааныг тодруулах, үнэмшилгүй тайлбар өгсөн гэж үзвэл ХХБ-т мэдээлэл өгнө.
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсны дараа ангидаа эргэн ирсэн хүүхдэд анги, сургуульдаа шоолуулах, гутаан доромжлогдох, гадуурхагдах байдлаар дахин хохирохоос хамгаалж, хүүхдийн нууцыг хадгалангаа анги хамт олонд нь зөв ойлголт өгч, зохисгүй харилцаа гарахаас урьдчилан сэргийлнэ.
5. Дээрх хүүхэд гэр бүл болон бусад орчинд дахин хүчирхийлэлд өртөж буй эсэхэд хяналт тавих ажиглалт, ярилцлага хийх, шаардлагатай тохиолдолд нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй хамт гэрийн эргэлт хийж, хүүхэд, түүний эцэг эх, асран хамгаалагчтай үүлзалт зохион байгуулна.
6. Сургуулийн хүүхэд хамгааллын мэдээлэл өгөх сувгуудын талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад тогтмол сурталчлан таниулна.
7. Ангийн Эцэг эхийн зөвлөлтэй хамтран эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүмүүжлийн эерэг аргыг сурталчлан таниулах, хүчирхийллийн эрсдэлт зан үйлээс урьдчилан сэргийлэх сургалт, үйл ажиллагааг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.
8. Хүүхдийн асуудлыг том, жижиг гэлгүй анхааралтай сонсдог, ямар нэг байдлаар хариулт өгдөг, хүүхдийн итгэдэг хүн нь байна. “Хов зөөдөг хүүхэд. Эцэг эх нь хэл амтай.” гэх мэт хувийн үзэл бодлоор асуудалд хандахгүй. Түүнчлэн гэмт хэрэгт холбогдсон, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үргэлж тийм байдаг гэж авч үзэж байнга буруутган шүүмжлэхгүйгээр өгөхгүй, хүүхэд өөрчлөгддөг гэдгийг ойлгосон байна.
9. Ангидаа аюулгүй байдлын хавтастай байна. Энэ хавтаст сургуулийн хэмжээнд мөрдөгдөж буй аюулгүй байдлын журам, анхны тусламж үзүүлэх анхан шатны заавар болон гамшиг, онцгой байдлын үед ангиас хамгийн ойр байрлах аврах гарц руу хүрэх зураг зэрэг ерөнхий мэдээллүүд багтана.
10. Ямар нэг таагүй асуудалд орсон хүүхдийн дэлгэрэнгүй мэдээллийг анги дотор нь ярихгүй байх, нууцыг сайтар хадгалж, ямар ч тохиолдолд хүүхдийг буруутгахгүй байх зарчмыг баримтална.
11. Хичээлийн жилийн эхний эцэг, эх, асран хамгаалагчдын хурлын үеэр “Хүүхдийн фото зургийг авах, ашиглах зөвшөөрөл” авна. Зөвшөөрөл өгөөгүй хүүхдийн зургийг цахим орчинд болон бусад байдлаар ашиглахгүй.
12. Хүүхэдтэй ямар нэг байдлаар таагүй харилцаа үүсгэсэн бол насанд хүрсэн хүн гэдгээ санаж, сэтгэл хөдлөлөө удирдаж, маргаан зөрчил, үл ойлголцлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэнэ.



Нийгмийн ажилтан

Та бол боловсролын орчны хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэх мэргэжлийн хүн билээ. Тиймээс ХХБ-ийн гишүүд болон бусад багш, ажилтнуудын хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд манлайлал үзүүлж ажиллана.

1. Хүүхэд хамгааллын мэдээлэл хүлээн авах сүвгүүд, Хүүхэд хамгааллын баг болон гишүүдийн танилцуулгыг ойлгомжтой байдлаар бэлтгэн багш, ажилтнуудын өрөө, анги танхим, урлаг спорт заал, коридор, үүдний хүлээлгийн танхимд бусдад ил харагдах газар байрлуулан, багш, ажилтан, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдад тогтмол сурталчлан таниулна.
2. Шилжиж ирсэн болон шинээр элссэн хүүхэд, шинээр анги бүрдэх явцад тэдний эцэг эх, асран хамгаалагчдад дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулна.
3. Хичээлийн бус цагаар зохион байгуулдаг хүүхдийг оролцуулсан бүх төрлийн үйл ажиллагаанд (тэмцээн уралдаан зохион байгуулах, хүүхдийг аймаг, сум, хот хооронд тээвэрлэх, очсон газраа байрлуулах, хавар намрын хээрийн аялал хийх, үзвэр, үзэсгэлэн, музей үзэх, мод тарих, хог цэвэрлэх... гэх мэт) эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гаргах ажлыг Ажлын хэсэг байгуулан хийнэ. Эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг сургуулийн бүх ажилтнуудад танилцуулж, ажилдаа ашиглаж дадахад дэмжлэг үзүүлнэ.
4. Багш, ажилтнуудад "Хүүхэд хамгааллын үлгэрчилсэн загвар"-ын давтан сургалт, хүүхэд хамгааллын мэдлэг ойлголт нэмэгдүүлэх сургалтуудыг бие даан зохион байгуулах болон мэргэжлийн байгууллагаас авах зэргээр ажилтнуудыг чадавхжуулах төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлнэ.
5. Дотуур байрын хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд онцгой анхаарал хандуулж, байрын багшийг дэмжиж ажиллана.
6. Хүүхдийг хүлээн авч ярилцах, бүлгийн ярилцлага хийх, гэр бүлтэй нь уулзалт зохион байгуулах зэрэг нийгмийн ажлын үйлчилгээг өдөр тутамдаа үзүүлнэ.
7. Сургуулийнхаа эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн судалгааг гаргаж, тэднийг хамгаалахад чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.
8. Хүчирхийлэлд өртөж, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхдийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, анги удирдсан багштай хамт гэрийн эргэлт хийх, тусгай хэрэгцээт хүүхэд бол гэр бүлд нь хүрч үйлчилнэ.
9. Сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүмүүжлийн эерэг аргыг сурталчлан таниулах, хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улиралд 1-2 удаа зохион байгуулна.

10. Үе тэнгийн дарамт, дээрэлхэл, ялгаварлан гадуурхалт, зүй бус хандлагыг бууруулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршилд автахаас сэргийлэх зорилгоор ганцаарчилсан болон нөлөөллийн ажлыг ганцаарчилсан, бүлгийн, ба нийт хүүхдэд хандсан арга хэлбэрээр зохион байгуулна.



Сэтгэл зүйч

Сургуулийн сэтгэл зүйч нь хүүхэд, багш, ажилтнуудад мэдлэг, мэдээлэл түгээх, нөлөөлөх, хүүхдийн насны хөгжлийн онцлог, түгээмэл тохиолдох асуудлууд түүний эрсдэлийг тооцож сургалт явуулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, оношилгоо хийх зэрэг ажлуудыг хариуцан ажилладаг.

1. Хүүхдийн дунд хүчирхийллийн эрсдэл илрүүлэх асуумж, түргэвчилсэн оношилгоо явуулан анхаарах шаардлагатай хариу гарсан хүүхдүүдийг нууцлал хадгалах зарчим баримталж, бүлгийн зөвлөгөө, сургалтад хамруулан эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.
2. Үе тэнгийн дээрэлхэл гарсан, гарах эрсдэлтэй анги, бүлгүүдэд бүлгийн зөвлөгөө, сургалт, дасгал ажлууд зохион байгуулж, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.
3. Сэтгэл хөдлөл мэдрэмжээ ажиглах, илэрхийлэх, бусдын ялгаатай байдлыг ойлгож, хүлээн зөвшөөрөх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг амьдрах үр чадварыг дэмжих агуулга бүхий хүүхдүүдэд чиглэсэн цуврал сургалт зохион байгуулна.
4. Хүүхэдтэй ганцаарчилсан уулзалт хийж, илэрсэн асуудлуудыг ХХБ-тай хэлэлцэх, шаардлагатай асуудлуудыг холбон зуучилна. Ингэж ажиллахдаа хүүхдийн дээд эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, ямар ч тохиолдолд тэднийг буруутгахгүй.
5. Багш, ажилтнуудад хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, харилцах арга барилын талаар сургалт зохион байгуулна. Мөн эрсдэлт нөхцөлд амьдардаг, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдтэй харилцахад зөвлөн тусална.
6. Хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, хэрэгцээний талаар сургалт мэдээллийг СНА, Эцэг эхийн зөвлөлтэй хамтран зохион байгуулна.
7. Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн нас, сэтгэл зүйн онцлог, эрх, хамгааллын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ХХБ, Эцэг эхийн зөвлөлтэй хамтран зохион байгуулна.
8. Хүчирхийлэлд өртөж, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхдийг дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, СНА болон Анги удирдсан багштай хамт гэрийн эргэлт хийх, тусгай хэрэгцээт хүүхэд бол сургуулийн дэмжлэгийн багийн гишүүдтэй хамт гэр бүлд нь хүрч үйлчилнэ.
9. Үе тэнгийн дарамт, дээрэлхэл, ялгаварлан гадуурхалт, зүй бус хандлагыг бууруулах, гэмт хэрэгт өртөх, хорт зуршилд автахаас сэргийлэх зорилгоор ганцаарчилсан болон нийт хүүхдийн дунд нөлөөллийн ажил зохион байгуулна.



Сургалтын менежер

Хүүхдийн хичээл сурлагын амжилт зөвхөн багш юм уу, тухайн хүүхдийн хичээл зүтгэлээс хамаардаггүй. Таагүй асуудалтай нүүр тулсан хүүхдийн сэтгэл санааны байдлаас хамаарч сурлага нь муудах, хоцрогдох, цаашлаад сургууль завсарддаг. Та ХХБ-ийн гишүүний хувьд хүүхэд, түүний гэр бүлтэй уулзах, тэднийг буруутгалгүй асуудлыг нь сонсож, хичээл сургалтад нь өөрийн чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлэх нь хүүхдийн ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм шүү.

1. Улирал тутам хичээл таслалт ихтэй сурагчдын мэдээллийг Анги удирдсан багшаас авч, хүүхэд, эцэг эх, анги удирдсан багш, СНА-тай хамтарсан уулзалт хийж, хүүхдийг сургууль завсардахаас сэргийлэх төлөвлөгөө гаргаж ажиллана.
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн сурлага, хөгжлийн явцын талаар эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан багштай мэдээлэл солилцох, зөвлөгөө өгөх ажлыг сар бүр, шаардлагатай бол тухай бүрд нь зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.
3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрлүүд, түүний шинж тэмдэг, илрэх байдлын талаар мэдлэгтэй байж, өөрөө түүнийг үйлдэхээс ямагт татгалзаж, хүүхэд хүчирхийлэлд өртсөн болохыг мэдсэн, сэжиглэсэн, таамагласан тохиолдолд ХХБ-т шууд мэдээлнэ

Захирал



Та бол сургуулийн Хүүхэд хамгааллын багийн ахлагч. Таны удирдлага, зохион байгуулалт, дэмжлэг, шийдвэрээс хамаарч сургууль, дотуур байрын орчинд хүүхдийг хамгаалах үйл ажиллагаа амжилттай хэрэгжинэ. Иймээс та өөрөө хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт сайтай байж, үр дүнд суурилсан хөтөлбөр, төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлснээр аюулгүй, хамгаалагдсан сургуулийг бий болгож чадна.

1. Шинэ ажилтан сонгон шалгаруулахад мөрдөх журамд хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журмын заалтуудыг оруулах. Үүнд:
 - Ажил горилогчийн өмнө ажиллаж байсан байгууллагын удирдлагаас “Хүүхдийн эрхийн зөрчил үйлдэж байгаагүй” тухай болон бусад тодорхойлолтуудыг авна.
 - Шинэ ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам”-ыг танилцуулж, гарын үсэг зуруулах ажлыг бичиг хэргийн ажилтанд хариуцуулж, хэрэгжилтэд хяналт тавина. Энэхүү дүрэм нь жил бүр Хөдөлмөрийн гэрээний хамт сунгагдаж явна.
2. Багш, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх сургалтын жагсаалтад “Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам”-ын сургалтыг хагас жил тутам заавал зохион байгуулж байхаар тусгаж, хэрэгжүүлнэ. Сургалтыг дараах 2 төрлөөр явуулна.
 - Шинээр ажилд орсон багш, ажилтнуудад танилцуулга сургалт (шинэ ажилтан ажилд орох өдрөөс өмнө заавал хамрагдана.)

- Ажиллаж байгаа бүх багш, ажилтнуудад журмыг сануулж, дадуулах ажлын байран дахь сургалтыг хичээлийн жилийн эхэнд болон 2-р улирлын сурагчдын амралтаар тус тус зохион байгуулна.
- 3. Сургуулийнхаа “Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн мэдээллийг хүлээн авч, хариу арга хэмжээ авах үйл явцын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хянах, ирсэн мэдээлэлд авч буй арга хэмжээ цаг хугацаандаа, чанартай хийгдэж байгаа эсэхэд хяналт тавина. Мөн ирсэн мэдээллийн агуулгад анализ хийж, ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллана.
- 4. Харьяа нутаг дэвсгэрийнхээ Хамтарсан баг, ХГБХХХ, Хүүхдийн хууль зүйн хороо, Хүүхдийн эрхийн улсын байцаагч болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, сургуулийнхаа нийт ажилтнуудад хүүхэд хамгааллын асуудлуудыг таних, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу арга хэмжээ авах ойлголт, чадавхыг нэмэгдүүлнэ.
- 5. Сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина.

БҮЛЭГ 3

**СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧНЫ
АЮУЛГҮЙ ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ**

Сургууль, дотуур байрын орчин нь хүүхэд бүр сурч хөгжихөд таатай, аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүчирхийлэлгүй байх ёстой. Энэ орчинд хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлөх, хүчирхийлэл, дарамтад өртөхөд хүргэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг сургуулийн удирдлага, багш, ажилтнууд, эцэг эхчүүд, хүүхдүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх бөгөөд гарч болзошгүй эрсдэлийг системтэйгээр үнэлж, түүнийг бууруулах арга хэмжээг авснаар аюулгүй, хамгаалагдсан сургууль, дотуур байрыг бий болгоно. Сургуулиас зохион байгуулж буй хэдий ч сургууль, дотуур байрын бүсээс өөр газар явагдаж байгаа (жишээлбэл, мод тарих, нийтийн цэвэрлэгээ хийх, тэмцээн уралдаан, аялал зохион байгуулах... гэх мэт) бүхий л үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулахын өмнө доорх шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тухайн үйл ажиллагааг хариуцаж буй¹ багш, ажилтнууд урьдчилан шалгаж, захирлаар батлуулна.

3.1. СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН ОРЧНЫ ЭРСДЭЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ШАЛГУУР ХУУДАС

Аюулгүй байдлын шалгуур хуудасны зорилго нь эрсдэлийг бууруулахаас гадна сургуулийн аюулгүй байдлыг бүхэлд нь хангаж, сурагч, багш ажилтнуудын аюулгүй байдал, сайн сайхан байдалд чиглүүлэх явдал юм.

Шалгуур хуудсыг тогтмол ашигласнаар:

- Сургуулийн аюулгүй байдал, түүний түвшнийг үнэлэхэд сургуулийн удирдлагад бодитой туслалцаа үзүүлэх;
- Анхаарах эрсдэлүүдийг тодорхойлж, засан сайжруулж, урьдчилан сэргийлэхэд сургуулийн удирдлагад туслах;
- Сургуулийн аюулгүй байдлын асуудалд тогтмол хяналт тавьж ажиллах;
- Эрсдэл, аюулгүй байдлын талаар тогтмол мэдээллийн систем ажилладаг болох;

Сургууль нь аюулгүй байдлын шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгах хуудсыг 7 хэсэгт хуваасан. Дотоод хяналтын баг нь сар бүр шалгуур хуудасны дагуу үнэлгээ хийж, тайланг удирдлагын баг, бусад ажилтнуудад танилцуулна. Дотоод хяналтын баг үнэлгээг хэрхэн хийх талаар тодорхой арга зүйн заавар удирдамж сургууль бүр боловсруулна. Тухайлбал: хяналтын багийн гишүүд хоёр хоёроороо тухайн орчинд өөрсдийн биеэр ажиглалт хийж бодит байдлыг шалгана. Хэн нэгний амаар үнэлэхгүй гэх мэт. Түүнчлэн орчны ажиглалтыг хийсэн багийн гишүүдийн нэрс, гарын үсгээр баталгаажуулна. Эрсдлийн зургийг авч оруулах, эрсдлийг арилгасныг зургаар баталгаажуулна.

- Шаардлага хангасан бол “ТИЙМ”
- Шаардлага хангаагүй бол “ҮГҮЙ” гэсэн сонголтыг тэмдэглэж, тайлбар хэсэгт үүссэн эрсдэлийг тодорхой бичиж, авах шаардлагатай арга хэмжээг төлөвлөнө.

¹ Үүнд тухайн арга хэмжээг удирдан зохион байгуулж байгаа болон өөр байгууллагын зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулж буй багш, ЗАН, ажилтнууд багтана.

А. Сургууль, анги танхимын аюулгүй байдлын шалгуур хуудас

БҮЛЭГ 3

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм / Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Сургууль, дотуур байрын шал, хаалга, цонхны бүрэн бүтэн байдал		
2.	Сургууль, дотуур байрын хашаа, хаалганы бүрэн бүтэн байдал		
3.	Ангийн гэрэлтүүлэг, агааржуулалтын ажиллагаа бүрэн эсэх		
4.	Цахилгааны утас, уртасгагч залгуур нь тээглэж унахаас сэргийлсэн тэмдэглэгээ, наалттай, дээр нь шингэн зүйл асгарахаас сэргийлсэн хамгаалалттай эсэх		
5.	Цахилгааны утас бүрэн хамгаалалт хийгдсэн эсэх		
6.	Цахилгааны үүсгүүр хүүхдээс хол, цоожтой хайрцагт байрлуулсан эсэх		
7.	Анги, дотуур байрын цахилгааны залгуур болон утас нь бага насны хүүхэд хүрэхгүй газар байх, ашиглаагүй үед цахилгааны залгуурыг таглах, эсвэл салгасан байх		
8.	Гэрэлгүй харанхуй хэсгүүд байгаа эсэх		
9.	Галын хор бүрэн ажиллагаатай болон цэнэглэлтийн хугацаа хүчинтэй эсэх		
10.	Сургуулиас 150 метр хүртэлх зайд траншейны таггүй нүх, хамгаалалтын хашаа, хаалтгүй гүнзгий нүх, суваг, бүх төрлийн задгай хог хаягдал байгаа эсэх		
11.	Сургуулиас 150 метр хүртэлх зайд хүүхдийн эрүүл мэндэд харшлахуйц хогийн ургамал, шарилж байгаа эсэх		
12.	Гадаад орчны дуу чимээ бууруулах арга хэмжээ авсан эсэх		
13.	Аврах гарцыг хааж тавилга, сандал ширээ байрлуулсан эсэх		
14.	Хогийн цэгийн эрүүл ахуй, хог ачилт тогтмол хийгддэг эсэх		
15.	Анги, танхимд хүүхдийн бие, хувцас ураг хадаастай, унаж бэртэж болзошгүй эвдэрхий ширээ, сандал байгаа эсэх		
16.	Гадаах талбайн болон спортын тоног төхөөрөмжүүдэд эвдрэл гэмтэл байгаа эсэх		
17.	Гал тогооны хэрэглэгдэхүүнүүд нь стандарт хангасан эсэх (хоол үйлдвэрлэж байгаа тогоо, шанага болон бусад хэрэгслүүд)		

18.	Гал тогооны ажилтнууд нь эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдаж, карт бөглөдөг эсэх		
19.	Гал тогоонд хэрэглэж байгаа газ болон цахилгааны аюулгүй байдлын карт бүрэн хөтлөлттэй эсэх		
20.	Аяга,тавагбусадзүйлсийнариутгал,халдваргүйжүүлэлт стандартын дагуу хийгддэг эсэх		
21.	Хүүхдэд худалдаалж байгаа хоол зууш, үдийн хоолны тэжээлийн илчлэг, зохистой найрлагад хяналт тавьдаг эсэх		
22.	Ус цэвэршүүлэгчийн фильтрийн хугацаа хүчинтэй эсэх		
23.	Ус цэвэршүүлэгчийн цорго хэвийн ажиллагаатай эсэх		
24.	Бие засах өрөөний 1 хүүхдэд ногдох ашиглалтын талбай хүртээмжтэй эсэх		
25.	Бие засах өрөөний хаалга, цонх, түгжээ, хогийн сав, гэрэлтүүлэг, угаалтуурын цорго бүрэн ажиллагаатай эсэх		
26.	Бие засах өрөөний цэвэрлэгээг бүртгэдэг карт хөтөлдөг эсэх, тэрхүү карт нь бие засах өрөөнд байрладаг эсэх		
27.	Биеийн тамирын хувцас солих өрөөний хаалга, цоож бүрэн бүтэн эсэх		
28.	ШУ-ны хичээлийн танхимуудад ашигладаг туршилтын урвалж, хэрэглэгдэхүүний хадгалалт, хамгаалалт хүүхдэд аюулгүй байдлаар хийгддэг эсэх		
29.	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд зориулсан дэд бүтэц байгаа эсэх (гарц, орц, шат, уух ус, 00)		
30.	Анхны тусламжийн хайрцаг доторх хэрэглэгдэхүүний хугацаа хүчинтэй эсэх		
31.	Хананд тавьсан тавиур болон шүүгээг аюулгүй байдлаар бэхэлсэн эсэх		
32.	Сургуулийн камерыг хуульд зөвшөөрөгдсөн журмын дагуу зөв, хэрэгцээтэй газраа байрлуулсан эсэх		
33.	Сургуулийн камер ашиглалтын журам байгаа эсэх (бичлэг хадгалалтын аюулгүй байдал, нууцлал, шалгах эрх бүхий хүн, бичлэгийн чанар зэргийг тодорхой тусгасан)		

Б. Сургуулийн автобус болон сургууль, дотуур байрын бүсээс өөр газар зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд сурагчдыг тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийг шалгах хуудас

БҮЛЭГ 3

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм / Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Тээврийн хэрэгсэл дээр сургуулийн нэр, байршил, утасны дугаар, “хүүхэд тээвэрлэж байгаа” тэмдэглэгээг харагдахуйц байдлаар байршуулсан эсэх		
2.	Тээврийн хэрэгслийн суудлын бүс, цонх, хаалганы бүрэн бүтэн байдал хангагдаж байгаа эсэх		
3.	Галын хор, анхны тусламжийн хайрцаг байрлуулж, хангалтыг бүрэн хийдэг эсэх		
4.	Аюулгүй ажиллагааны болон яаралтай үед авах арга хэмжээний зааварчилгаа тээврийн хэрэгсэл дотор хүүхдэд ойлгомжтой, тайлбартай байрлуулсан эсэх		
5.	Сургуулийн автобусны жолооч нь 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, хүүхдийн эрх, хамгааллын сургалтад хамрагдсан, Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журамтай танилцаж, гарын үсэг зурдаг эсэх		
6.	Зорчигч хүүхдүүд нэгнээ дээрэлхэх нөхцөл үүсгэхгүйгээр зохицуулах, гэмтэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бага ангийн хүүхдүүдийг илүүтэй анхаарах		

В. Сургууль руу гаднын хүн нэвтрэх үеийн аюулгүй байдлыг шалгах хуудас

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм/Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Сургууль, дотуур байр руу нэвтрэх гэж буй хүн бүрийн зорилго, уулзах хүний нэр, орж гарсан цаг, минутыг бүртгэдэг эсэх		
2.	Сургууль, дотуур байр руу нэвтэрч буй гаднын хүнд “Зочин” гэсэн үнэмлэх өгдөг эсэх		
3.	Гаднын зочныг сургууль дотор байх хугацаанд хаана, хэнтэй уулзаж байгааг хянадаг эсэх		

Г. Яаралтай тусламжийн бэлэн байдлыг шалгах хуудас

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм/Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Яаралтай тусламжийн үед үзүүлэх нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургуулийн хамгааллын багийн аюулгүйн багц ¹ бүрэн эсэх		
2.	Яаралтай тусламжийн үед ашиглах ажилтнууд, сурагчдын утас, гэрийн хаягийн нэгдсэн бүртгэл байгаа эсэх. Тухайн бүртгэл хагас жил тутам шинэчлэгддэг эсэх		
3.	Яаралтай тусламжийн үед хамтран ажиллах, дэмжлэг авах байгууллагуудын мэдээлэл, бүртгэл байгаа эсэх		
4.	Яаралтай үед багш, сурагч, ажилтнуудын хоорондоо ойлголцох нууц дохио, хэл ашиглах дадлага хийгддэг эсэх		
5.	Гамшиг, онцгой байдал, гал түймэр, газар хөдлөлт, байгалийн гамшгийн үед авах аюулгүй байдлын төлөвлөлт, дадлага сургуулилт тогтмол хийгддэг эсэх		
6.	Яаралтай тусламжийн үед туслах сайн дурын дэмжигч багийг сургаж бэлтгэсэн эсэх		

Д. Яаралтай тусламжийн үед эмчийн өрөөний бэлэн байдлыг шалгах хуудас

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм/Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Сургуулийн эмчийн өрөө нь эмнэлгийн яаралтай анхан шатны тусламж үзүүлэх боломжтой эсэх		
2.	Яаралтай тусламжийн үед ашиглах бүх хүүхдүүдийн эрүүл мэндийн мэдээллийн дата байдаг эсэх, түүний нууцлалыг бүрэн хангадаг эсэх		
3.	Нийт сурагчид, багш ажилтнуудын харшлын мэдээлэл бүртгэл		
4.	Хүүхдийн өдрийн хоолны илчлэг, эрүүл ахуйд тавих хяналтын карттай эсэх		
5.	Сургуулийн ОО, гал тогоо зэргийн ариун цэвэр, эрүүл ахуйд тавих хяналтын төлөвлөгөөтэй, түүнийг хэрэгжүүлдэг эсэх		

¹ Гамшиг, онцгой байдлын үед ашиглах бүртгэл мэдээлэл, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх анхан шатны үнэлгээний маягтууд болон анхны тусламжийн хэрэгслүүдээс бүрдсэн багц.

Е. Сургуулийн цахим орчны аюулгүй байдлыг шалгах хуудас

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм/Үгүй	Нэмэлт тайлбар
1.	Сургууль, дотуур байрын орчинд цахим ашиглах журамтай эсэх		
2.	Сургуулийн ангийн эцэг эх, багш ажилтнуудын чат групп, фейсбүүк дээр хүүхдүүдийг оролцуулахгүй, бусад хамааралгүй хүмүүсийг нэвтрэх боломжийг хязгаарласан эсэх		
3.	Сурагчдын насанд тохирсон арга барилаар цахимын аюулгүй хэрэглээ, хариуцлагатай дижитал иргэн болох талаар сургах сургалтын төлөвлөгөөтэй эсэх		
4.	Цагдаагийн газрын цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст хэрхэн хандахыг бүх сурагчид, багш ажилтнуудад сурталчлан таниулдаг эсэх		
5.	Эцэг эх, багш нар болон бусад ажилтнууд сургуулийн цахим бодлого, технологийн аюулгүй хэрэглээ, интернэтийн зөв хэрэглээ, эрсдэлээс зайлсхийх талаар мэдлэгжүүлэх үйл ажиллагаа хийгддэг эсэх		

3.2. ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН БЭЛЭН БАЙДЛЫГ ШАЛГАХ ХУУДАС

Гамшгийн үед ялангуяа түүнээс гарах үр дагавар удаан хугацаанд үргэлжилсэн тохиолдолд хүүхдийн сурч боловсрох эрх хязгаарлагдах, зөрчигдөх ёсгүй бөгөөд боловсролыг үргэлжлүүлэн олгох явдал нь Засгийн газрын нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл байх ёстой. Тайван үед хүүхэд хамгааллын аливаа бэлэн байдлыг тогтмол шалгаж хангаж, бэлтгэл сургуулилт сайн хийснээр гамшиг, онцгой байдлын үеийг ч хохирол багатай даван туулах боломжтой.

№	Аюулгүй байдлын үзүүлэлтүүд	Тийм/Үгүй	Нэмэлт тайлбар
1	Гамшиг онцгой байдлын хариу арга хэмжээ, хүний нөөцийн оролцооны төлөвлөгөөтэй эсэх		
2	Гамшиг онцгой байдлын хариу арга хэмжээний дадлага сургуулилтыг мэргэжлийн байгууллагатай хамтран багш ажилтнууд, сурагчдын насны хөгжлийн онцлогт тохируулан тогтмол зохион байгуулдаг эсэх		
6.	Гамшиг онцгой байдлын хариу арга хэмжээний үед ашиглах бүх хүүхэд, багш, ажилтнуудын утас, гэрийн хаягийн мэдээлэл хагас жил тутам шинэчлэгддэг эсэх		

7.	Гамшгийн үед ашиглах хүүхдэд ээлтэй орон зай, түр хичээллэх байрын төлөвлөлттэй эсэх		
8.	Суурь боловсролоос гадна эрүүл мэнд, танин мэдэхүй, хүүхдийн хувийн хөгжилд зориулсан сэдвээр явуулах сургалтын төлөвлөгөөтэй эсэх		
9.	Хүүхдийн тоог нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр нь бүртгэсэн бүртгэлтэй эсэх		
10.	Сургалтад хэрэгцээтэй материалын нөөцтэй эсэх		
11.	Гамшгийн улмаас цочролд орсон, сэтгэл санаа нь зовуурилсан хүүхдэд сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх чадварыг хүүхэд, багш, ажилтнууд эзэмшсэн эсэх		
12.	Гамшгийн үед сэтгэцийн эрүүл мэндийн хариу урвал хүчтэй гарах үед тайвшруулах, зөв шийдвэр гаргахад туслах багтай эсэх		
13.	Орц, гарцын аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэх		
14.	Ариутгал, халдваргүйтгэлийн бэлэн байдлыг хангасан эсэх		
15.	Галын хорын хугацаа, бүрэн ажиллагааг шалгасан эсэх		
16.	Ажлын байран дээрээ байхад гамшиг болсон тохиолдолд ажилтнуудын ар гэрүүдийг зохион байгуулах төлөвлөгөөтэй эсэх		
17.	Яаралтай тусламжийн үед ажилтнуудтай холбогдох мэдээллийн урсгалыг хүн бүр мэдэх дадлагыг сард 1 удаа тогтмол явуулдаг эсэх		

Гамшиг, онцгой байдлын үеийн боловсрол гэдэг нь гамшгийн үед боловсролын тасралтгүй байдлыг хангах зорилготой нэгдмэл цогц үйл ажиллагаа юм. Гамшгийн үеийн боловсрол нь түр зуурын, явуулын сургууль байгуулах, сургалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд материалаар хангах, хоол хүнс, сургагч багшаар хангах болон сурталчлан таниулах ажиллагаа зэргээс бүрдэнэ.

3.3. СУРГУУЛИЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ, ХАМГААЛАГДСАН БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Сургуулийн орчны эрсдэл, асуудал, нөхцөл байдал байнга хувьсан өөрчлөгддөгийг мэддэг байх

Сургуулийн орчны эрсдэлүүд байнга өөрчлөгдөж байдаг. Нэг удаагийн дотоод хяналтаар илэрсэн асуудлуудыг шийдвэрлэснээр дараа дахиж ийм асуудал гарахгүй гэсэн үг биш. Мөн шинэ сурагчид, шинэ багш нар ирэх, шинэ нөхцөл байдал үүсэх бүрийд шинэ асуудал, эрсдэлүүдтэй тулгарна гэдгийг ойлгож, бэлтгэлтэй байх нь чухал юм. Хяналтаар илэрсэн эрсдэлүүдийг цаг алдалгүй шийдэх хэрэгтэй. “Ингээд байж байдаг. Гайгүй дээ” гэсэн хандлагаар хандаж, хайхрахгүй орхивол дараагийн удаад сурагчид хүнд гэмтэл бэртэл авах, илүү ноцтой хохирох асуудал үүсэж болзошгүй юм.

2. Орон нутгийн эрсдэлийн зураглал хийдэг байх

Жил бүрийн хичээлийн жилийн эхэнд сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтнууд тус бүрдээ орон нутгийн зураглал хийх дасгал хийж, сургууль, дотуур байрны орчны эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг нэн даруй авах, сургууль жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгахаас гадна шаардлагатай тохиолдолд сургуулийн Эцэг эхийн зөвлөлтэй хамтран ажиллах нь үр дүнтэй.

3. Сургуулийн орчимд амьдардаг айлуудтай хөршийн холбоог бэхжүүлэх

Сургуулийн аюулгүй байдлыг хангахын тулд эргэн тойронд амьдардаг хүмүүс, бизнес эрхлэгчдийг сургуулийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл, заналхийлэл, аюулыг тодорхойлоход татан оролцуулж болох юм. Учир нь тэд сургуулийн эргэн тойрон дахь хүүхдэд учирч болзошгүй эрсдэлүүд, сэжиг бүхий хүмүүс болон бусад асуудлуудыг анзаардаг, мэдээлэл сайтай байж болно. Тиймээс эдгээр хүмүүс, байгууллагуудтай харилцаа холбоо тогтоосноор сургууль хүүхдэд эрсдэлтэй байж болзошгүй асуудлуудыг эрт илрүүлэх боломж нэмэгдэнэ. Гэвч эдгээр байгууллага, иргэдэд сургуулийн хүүхэд хамгааллын багаас хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, журмын сургалтад хамруулна.

4. Сургуулийн хаалга, хашааны бүрэн бүтэн байдал

Хашаа нь сурагчдын аюулгүй байдлыг хангахад энгийн боловч үр дүнтэй. Энэ нь бага ангийн сурагчдыг олны дунд төөрөх, автомашин, дугуй, скүүтер зэргийн хөдөлгөөнийг хязгаарлах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн болон буруу сэдэл санаатай хүмүүсээс хамгаалдаг. Сургуулийн хашааг стандартын дагуу барьж, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах хэрэгтэй. Сургуулийн анги, коридорын хаалга нь зөв онгойж, зөв хаагддаг байна.

5. Сургуульд гаднын хүн нэвтрүүлэх

Сургуульд гаднын хүнийг ямар ч хяналтгүйгээр хүссэнээрээ орж, гарахыг зөвшөөрөх нь бүх хүмүүст аюултай байж болзошгүй. Тиймээс тэднийг бүртгэх, орох зөвшөөрөл олгох, сургууль дотор байх хугацаанд нь хяналт тавих маш сайн журамтай байх нь чухал. “Зочин”-ны үнэмлэх ашиглах нь сурагчдад гаднын хүнийг таних, тэдэнтэй харилцахдаа болгоомжтой байх боломж олгодог. Бичиг баримтгүй, согтууруулах ундаа хэрэглэсэн хүнийг нэвтрүүлэхийг хориглоно. Сургуульд сурагчид, багш ажилтнууд, гаднын зочдыг нэвтрүүлэхдээ QR код бүхий цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх боломжтой.

6. Камержуулалт

Хяналтын камерыг сургууль, дотуур байрын гадна болон дотор орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглана. Камерыг ашиглахдаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг мөрдөж ажиллана. Хяналтын камер нь нягтрал сайтай, харанхуйд бичлэг хийх боломжтой, 7 хоногоос багагүй хугацаанд бичлэг, мэдээллийг хадгалах багтаамжтай байх ба хуулиар хориглосноос бусад газарт байрлуулна. Сургууль нь хяналтын камер ашиглалтын журам боловсруулан баталж, бүх ажилтнууд дагаж мөрдөнө. Камерын хэвийн ажиллагааг хангах техникийн ажилтныг сургуулийн захирал томилох бөгөөд камерын бичлэгийг 7 хоног тутам шүүх, хадгалах ажлыг Нийгмийн ажилтан, Сургалтын менежер нар бүрэн хариуцна.

7. Аюулгүй байдлын хавтас

Анги бүр аюулгүй байдлын хавтастай байна. Энэ хавтаст сургуулийн хэмжээнд мөрдөгдөж буй аюулгүй байдлын журам, анхны тусламж үзүүлэх анхан шатны заавар зэрэг ерөнхий мэдээллүүд багтана. Түүнчлэн ангиас хамгийн ойр байрлах аврах гарц руу хүрэх чиглэлийг заасан зураглал байна.

8. Халтиргаа

Өвлийн улиралд сургуулийн гадаа болон дотор халтиргаа үүсэхээс өмнө цас орсон даруй цэвэрлэх материалуудаар холбогдох ажилтнуудыг хангаж, цэвэрлэгээний чанар захиргаа аж ахуйн алба тогтмол хяналт тавьж ажиллана. Сургуулийн коридор, гал тогоо, цайны газар, 00-д ус асгасан бол зайлшгүй арчиж, цэвэрлэж байхыг сурагчид болон багш ажилтнууд дадал болгосон байх нь бусдыг болон өөрсдийгөө болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэг арга юм.

ХАВСРАЛТ

**Тус материалд дурдагдсан Монгол Улсад мөрдөгдөж буй хүүхдийн эрх, хамгааллын
холбогдолтой хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт**

Хууль:

1. Боловсролын ерөнхий хууль, 2023 он
2. Газрын тухай хууль, 2002 он
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
4. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, 2019 он
5. Зөрчлийн тухай хууль, 2017 он
6. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он
7. Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он
8. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2024 он
9. Эрүүгийн хууль, 2021 он
10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2024 он

Журам:

1. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, 2024 он
2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм, 2022 он

Стандарт:

1. “ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ”, Ерөнхий шаардлага MNS6781 2019 он
2. Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, MNS 6948:2021



БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО ЖУРАМ

2019 оны 2 дугаар сар

(Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын эвслийн баримт бичгийг Монгол Улс дахь Хүүхдийг Ивээх Сангийн хөтөлбөрийн газар орчуулав.)

УДИРДАМЖ

Боловсролын үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого, журам

Сургууль болон түр сургалтын орчин нь хүүхдүүд манай ажилтнууд, хамтрагчид, бусад хүүхдүүдийн зүгээс бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй газар болдог нь харамсалтай. Энэ удирдамж нь боловсролын хөтөлбөрүүдийн хүрээнд гарч болзошгүй эрсдэлүүдийг тоймлож, түүнийг хэрхэн удирдаж, хүүхдүүдийг аль болох аюулгүй байлгах талаар зөвлөмж өгөх болно.

Сургууль болон түр сургалтын орчин дахь хүчирхийллийн түгээмэл хэлбэрүүд



Бие махбодын шийтгэл



Бэлгийн хүчирхийлэл ба мөлжлөг



Сэтгэл санааны хүчирхийлэл

“Хүн”-ээс үүдэлтэй эрсдэлүүд

- “Бие махбодын шийтгэл нь сургуульд сахилга бат, дэг журам сахиулдаг” гэж итгэдэг ажилтан, сайн дурынхан
- Багш, сурагч хоорондын тэгш бус **эрх мэдлийн динамик**, ялангуяа бэлгийн мөлжлөгт хүргэж болзошгүй жендерийн тэгш бус байдал, хэм хэмжээ (дүнгийн төлөө бэлгийн харьцаанд орох... гэх мэт)
- Бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Аюулгүй хөтөлбөрийн зарчмууд болон Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журмын **сургалтад хамрагдаагүй боловсролын баг**. Үүнд зөвхөн багш биш, туслах, харуул, жижүүр, цэвэрлэгчид зэрэг хүүхэдтэй тогтмол харилцдаг хүмүүс хамаарна.
- Өөрсдөө **сэтгэцийн гэмтэлтэй** байж болзошгүй багш, ажилтнууд, сайн дурынхан, бусад насанд хүрэгчид (асран хамгаалагчид мөн багтана). Эдгээр хүмүүс хүүхдүүдэд тусалж чадахгүй байж магадгүй.



Анхаарах гол зүйлс

1. Хүүхдийг багш, ажилтнуудтай **1:1-ээр, бусад хүмүүсээс хол, зайтай байх боломжийг хязгаарлах** нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлалыг эрс бууруулна.
2. Манай ажилтнууд болон сайн дурынхан сургууль дээр дэг журам сахиулахын тулд **бие махбодын шийтгэл** хэрэглэж сурсан байж болзошгүй. Тэдэнд шинэ арга барилд суралцахад зөвлөгөө, тусламж хэрэгтэй.
3. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам, ялангуяа аюулгүй хөтөлбөрийн талаар **тогтмол сургалт** хийж байх нь ажилтнууд, сайн дурынхан, гэрээлэгчдэд хүүхдийн өнцгөөс бодож, эрсдэлээс зайлсхийхэд тусалдаг.
4. Багш, ажилтнууд, сайн дурынхан, бусад насанд хүрэгчид (асран хамгаалагчид мөн багтана) **өөрсдөө сэтгэцийн гэмтэлтэй** байж болзошгүй бөгөөд хүүхдүүдэд илүү сайн туслахын тулд тэдэнд нэмэлт дэмжлэг шаардагдах магадлалтай.
5. **Эрсдэлийн удирдлага бол идэвхтэй, тасралтгүй, хэзээ ч зогсдоггүй үйл явц** юм. Хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахын тулд бие биедээ шаардлага тавьж, хянахаас санаа зовох, айх хэрэггүй.

- **Ялгагдахгүй байх.** Жишээлбэл, ажилтнууд ажлын үнэмлэхээ зүүдэггүй, байгууллагын цамц, хувцас өмсдөггүй, халаа сэлгээ ихтэй байдлаас үүдэн хүүхдүүд ажилтнуудыг гаднын хүмүүсээс ялгаж танихад хэцүү байдаг.
- Сургуулийн болон бусад хөтөлбөрийн бүс рүү ажилтнууд, гадны хүмүүс **хяналтгүй нэвтрэх.**
- Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн шинж тэмдгүүдийг танихгүй, санаа зовоосон асуудалд яаралтай арга хэмжээ авч чадахгүй байж болзошгүй бэлтгэгдээгүй, ажилд хурдан орсон, **хангалттай чиглүүлэг байхгүй** ажилтнууд.
- Сургуулийн бүс дотор болон ойролцоо **аюул учруулж болзошгүй** хувь хүн, бүлгүүд байх. Жишээлбэл, цэргүүд, барилгачид, цэргийн анги, нэгтгэл... гэх мэт.
- Стресс ихтэй ажилтнууд бие махбодын шийтгэл хэрэглэх магадлал өндөр бөгөөд хүчирхийллийн шинж тэмдгүүдийг ажиглах анзаарга нь багасдаг.



“Хүн”-ээс үүдэлтэй эрсдэлийг хэрхэн бууруулах вэ?

- Боловсролын төсөл хэрэгжиж эхлэх үеэс орон нутгийн иргэд, удирдлагууд, шашны удирдагчид болон бусад нөлөө бүхий хүмүүстэй:
 - Хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдийг хэрхэн хамгийн сайнаараа хамгаалах талаар;
 - Манай ажилтнуудын баримтлах ёстой зан үйлийн талаар;
 - Аливаа асуудлыг хэрхэн мэдээлэх тухай;
 - “Хүүхэд хамгааллын баатар” болох;
 - Орон нутгийнхны аливаа асуудлыг мэдээлдэг зан үйл болон тэдний хүлээлтийн талаар ярилцах.
- **Ялгагдахгүй байдлыг бууруулах** – манай ажилтнууд ажлаа хийж байхдаа үргэлж Хүүхдийг Ивээх Сангийн цамцыг өмсөж байх, өөрийнхөө зурагтай ажлын үнэмлэхээ тогтмол зүүх, тухайн бүсэд ирсэн зочдыг бүтэн нэр, албан тушаалаар нь хүүхдүүдэд танилцуулж байх.
- Багш, ажилтнуудад хүүхэдтэй ажиллахдаа шийтгэл хэрэглэхийн оронд **ээрэг арга барил** ашиглах ур чадвар олгох.
- Хүүхэд, насанд хүрэгчдийг дэмжиж ажиллах багш, ажилтнуудын **сэтгэцийн гэмтлээ даван туулах чадварыг нь хөгжүүлэх.** Жишээлбэл, анхаарал төвлөрүүлэх дасгал, санамсрын бясалгал зэрэгт оролцуулах.



Зургийг: Эл Джэй Пасион/Хүүхдийг Ивээх Сан

- Ажилтнууд, хамгаалагч, харуул, жолооч нарт урилгагүй, гэнэтийн зочдыг сургуулийн бүсэд нэвтрүүлэхгүй байх **эрх олгох**.
- Сургуулийн бүх ажилтнуудад зориулсан сургалтад **Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам ба Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах** агуулгыг багтаах.
- Бүх багш, ажилтнууд, ялангуяа харуул, тогооч, жолооч нарт хүүхэдтэй хоёулхнаа үлдэх боломжийг эрэлхийлэх зэрэг эрсдэлтэй зан авир ажиглагдах, хэн нэгнээс ямар нэг **буруу үйлдэл мэдэгдвэл мэдээлэх** талаар сургаж, чиглүүлэх.

Хүүхдийг багш, ажилтнуудтай 1:1-ээр бусдаас хол байх боломжийг хязгаарлах нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх магадлалыг эрс бууруулна.
- Багш, ажилтнуудын зан үйлийн стандартыг тодорхойлсон Ёс зүйн дүрмийг бий болгож, түүнийг таниулах сургалт зохион байгуулж, бүх ажилтнууд гарын үсэг зурж байх. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчсөн тохиолдолд авах хариу арга хэмжээг тодорхойлсон бодлого хэрэгжүүлэх.
- Хүчирхийллийн сэжигтэй эсвэл батлагдсан тохиолдлууд болон хүүхэд хамгааллын бусад асуудлыг илрүүлэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах механизмтай байх. Энэ нь орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний механизмтай холбогдсон байх.
- Бүх багш, ажилтнууд болон хүүхдүүдэд мэдээлэх, холбон зуучлах механизмын талаар сургалт зохион байгуулах.
- **Хүүхэд бол бие даасан хувь хүн**, үнэ цэнтэй, 'мөлжлөг бол гэмт хэрэг' 'хүчирхийлэл нь хүүхдэд хор хөнөөл учруулдаг' зэрэг мэдээлэл, хүмүүжлийн эерэг мессежнүүдийг түгээх замаар олон нийтийг идэвхжүүлэх.
- Багш болон бусад ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжиж, стрессийг зохицуулж болох хэмжээнд хүртэл бууруулах.

ЖИШЭЭ: Халид бол дүрвэгч багш. Тэр Хүүхдийг Ивээх Сангийн дүрвэгсдийн хуаранд ажилладаг. Түүний амьдардаг байсан газар бие махбодын шийтгэлийг хэвийн гэж үздэг байсан тул тэр хоцорсон хүүхдүүдийг саваагаар цохидог байв.

11 настай Мэриам өглөө ажил хийдэг болохоор хичээлээсээ байнга хоцордог. Тэр цохиулахаас айснаасаа болж сургуулиасаа гарав. Мэриамийн ээж нь түүнийг сургуульд явдаггүй тул өдрийн цагаар аюулгүй байлгахын тулд 55 настай хөрштэйгөө гэрлүүлэхээр шийджээ.

Үндсэн хөтөлбөр болон үйл явцын эрсдэлүүд

- Сургууль болон орон нутгийнхан дундах **нийгмийн гадуурхалт, эв нэгдэлгүй байдал** (сургуулийн өглөө, өдрийн ээлжид хичээллэж буй янз бүрийн бүлгийн хүүхдүүд)
- Сургуульд суралцаж буй хүүхдүүд, ялангуяа **эмзэг хүүхдүүдэд чиглэсэн арга хэмжээ хангалтгүй**. (жишээлбэл, хараа хяналтгүй бага насны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өрх толгойлсон хүүхэд гэх мэт)
- Нэг ангид **янз бүрийн насны хүүхдүүд** холилдон суралцах нь үе тэнгийнхнээ дээрэлхэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- Хэрэв хөтөлбөр нь хүүхдийн хувцсыг солих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах зэргээр **хүүхдийн бие махбодод хүрдэг онцлогтой** бол энэ нь хүчирхийлэгчид хүүхдийн биед зохисгүй байдлаар хүрч буйгаа далдлахад хялбар болгодог.
- **Хамтрагчид, сайн дурын ажилтнууд** эсвэл олон нутгийн удирдлагаар (зохистой хяналтгүйгээр эрх мэдлийг шилжүүлдэг) дамжин хэрэгждэг хөтөлбөр нь бүх хэлбэрийн хүчирхийллийн (ялангуяа бэлгийн мөлжлөг) эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- Сургуульд хамрагдах (**дотуур байранд суух**), сургууль руу очих болон буцах зам (*танхайчуудын бүлэглэл/орон нутгийн орчин*)
- Боловсролын хөтөлбөрт элсэх **стандарт шалгуур** байхгүй. Эсвэл энэ талаар олон нийтэд муу мэдээлдэг.



Зургийг: Жорди Матас/ Хүүхдийг Ивээх сан

- Сургуулиуд дэг журам сахиулж, хяналтаа алдахгүйн тулд **бие махбодын шийтгэлийг хүлээн зөвшөөрөх** (*бие махбодын хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн хооронд хүчтэй холбоо хамаарал байдгийг анхаарна уу*)
- Ёс зүйн дүрэм, мэдээлэх, шилжүүлэх **механизм байхгүй**.
- Хүүхдийг ажилтан, хамтрагчтай **1:1-ээр бусдын хараа хяналтгүй** байхыг шаарддаг үйл ажиллагаа нь бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- Ажилтнууд болон хүүхдүүд нь зальдан мэхэлж, хор хөнөөл учруулж болохуйц хэрэгслүүд рүү **хяналтгүйгээр нэвтрэх**. (*интернэт гэх мэт*)
- **Хүүхдийг тээвэрлэдэг** хөтөлбөрүүд нь осол гэмтэл, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.
- Сургуулийн удирдлагын гол асуудлууд болон төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд **хүүхдийн оролцоо** хангалтгүй.
- Сургуулийн аюулгүй байдлын удирдлагын протокол дутмаг байдал нь хор хохирол, ослын эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Эдгээр эрсдэлийг хэрхэн бууруулах вэ?

- Хүүхдийг Ивээх Сангийн Аюулгүй сургууль аргачлалыг судалж, хэрэгжүүлэх
- Бүх боловсролын хөтөлбөрүүд хүүхдийг хэрхэн аюулгүй байлгах вэ гэдэг өнцгөөс харж, гарч болох эрсдэлийг системтэйгээр үнэлж, түүнийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх;
- Ойлгомжтой, хүүхдэд ээлтэй мэдээлэх механизм нь нууцыг хадгалдаг, байнгын ажиллагаатай байх (өдөрт дор хаяж 1 удаа шалгадаг);
- **Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам** (жишээлбэл, хүүхдүүд ажилтнуудаас ямар зан төлөвийг хүлээж болох) болон мэдээлэх механизмуудыг тайлбарласан мессежнүүдийг түгээх;
- Сургалтын хөтөлбөрт **аюултай, аюулгүй хүрэлт** болон харилцааны тухай агуулгыг оруулж, хүчирхийллийн шинж тэмдгүүдийг таних, хэрхэн мэдээлэх талаар хүүхдүүдтэй ярилцах. Хүүхдүүдийг өөрсдийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр сургалтад хамруулбал тэд өөрт болон найз нөхдөдөө тохиолдсон санаа зовоосон зүйлийн талаар илүү их мэдээлэл өгдөг гэдгийг бүх багш, ажилтнууд, бусад насанд хүрэгчдэд ойлгуулах;
- Сургалтын хөтөлбөрт нийгэм-сэтгэлзүйн сургалт, сэтгэл зүй-нийгмийн дэмжлэг үзүүлэх **арга хэмжээнүүдийг** тусгах;
- Хүйсийн тэгш байдлыг хангах, нийгмийн эерэг хэм хэмжээг сурталчлах асуудлаар багш, сургуулийн удирдлага, ажилтнуудтай уулзалт хийх;
- Хүүхдэд зориулсан сургалтын хөтөлбөрт жендерийн тэгш байдал, нийгмийн эерэг хэм хэмжээний тухай агуулгыг тусгах;
- Хүүхдүүдэд хүүхэд хамгааллын асуудал, холбон зуучлах, мэдээлэх механизмын талаар сургалт зохион байгуулах;
- Сургууль, орон нутагт нийгмийн оролцоог дэмжих;
- Хүүхэдтэй харьцаж буй бүх ажилтан, багш, сайн дурынхан, бусад насанд хүрэгчдийн өмнөх ажлын түүх, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх мэдээллийг шалгаж, Ёс зүйн дүрэм, Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журмыг танилцуулан гарын үсэг зуруулж, одоо байгаа мэдээлэх, холбон зуучлах механизмын талаар сургалтад хамруулах;
- Сургууль бүр дээр Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журмыг **хариуцсан хүнийг томилох** (өөр соёл, гарал үүсэлтэй, эрэгтэй, эмэгтэй 2 хүн байвал тохиромжтой);
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангахаар ажиглалт хийж буй боловсролын эсвэл хүүхэд хамгааллын сургагдсан ажилтнууд **газар дээр нь гэнэтийн шалгалт хийх**;
- Ажилд авах шалгалт – хэдийгээр ажилтан яаралтай ажилд авах шаардлагатай байсан ч хүний нөөцийн алба нь **ажилд авах аюулгүй практикийг дагаж мөрдөх**;
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журам, Ёс зүйн дүрэм зэрэг зан төлөвийг зохицуулдаг байгууллагын **дүрэм журмыг тодорхой зааж**, бүх ажилтнууд өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа тууштай баримталдаг байх;
- Боловсролын үйл ажиллагаанд **хамгааллыг нэвтрүүлэх** талаар Хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах
- Сургуулийн эргэн тойронд ажилтнууд эргүүл хийж, хүүхдүүдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг шалгаж, сургуулийн орчинд **хараа хяналтгүй газар** үлдээхгүй байх;

- **Багш сурагчдын тооны харьцаа** хэвийн байгаа эсэхийг баталгаажуулах;
- Насанд хүрэгчид болон хүүхдүүдэд ээлтэй, **нууцлалтай, аюулгүй мэдээлэх механизмыг** нэвтрүүлэх. Энэ нь сургууль болон боловсролын бусад хөтөлбөрийн бүсэд ашиглах боломжтой эсэхийг шалгана. Үнэ төлбөргүй утас эсвэл түүнтэй ижил төстэй аргууд байвал үр дүнтэй.
- Боловсролын бүх багш, ажилтнууд, ялангуяа жижүүр, тогооч, жолооч нарыг **сургаж, чиглүүлэх**. Ямарваа нэг асуудлын талаар мэдээлэх, эрсдэлтэй, хурц зан авир, муу дадал зуршил илрэх, эсвэл хүүхэдтэй ганцаараа үлдэх гэж оролдож байгаа хүн бий эсэхийг сайтар нягталж шалгаж байх;
- Хариуцсан байршилдаа хүчирхийллийн шинж тэмдгийг илрүүлбэл хэрхэн мэдээлэх талаар ажилтнууд болон орон нутгийн иргэдийг **сургаж, татан оролцуулах** (энэ нь тэдэнд өөрсдөд нь аюулгүй эсэхийг давхар шалгаарай);
- Ажилтнууддаа бодлого журам зөрчсөн болон санаа зовоосон асуудлуудыг тогтмол **мэдээлэх боломжийг олгож**, мэдээлэл өгснөөр ажлаа алдахгүй гэдгийг дахин сануулах;
- Ажилтан хүүхэд хоёр хоёулхнаа байх шаардлагатай, ялангуяа нэгнийхээ биед хүрэх шаардлагатай үйл ажиллагааны үед бусад хүмүүс тэднийг **харж, сонсох боломжтой газар** байх;
- Хүүхдүүд явж байгаа аливаа аялал, зугаалгад заавал **хүүхдийн тоонд тохирсон насанд хүрэгч** (хамгийн багадаа 2 том хүн) байх бөгөөд тээврийн хэрэгсэл болон зугаалах газар аль аль нь аюулгүй байх ёстой.
- Болзошгүй гэмт хэргийг хянах (хүүхдийг зальдан мэхэлж, хор хөнөөл учруулж болохуйц хэрэгслүүд) – жишээлбэл, олон нийтийн сүлжээгээр харилцахыг хязгаарлах, Мэдээллийн технологийн бодлого, хяналтын программ хангамж ашиглана.
- Боловсролын үйл ажиллагааг олон нийтэд хүргэхийн тулд багш нар, заах аргын нэгдэл, сайн дурын ажилтнууд, хамтрагчид болон сургуулийн нийт хамт олон өөрсдийн ёс зүйн дүрмийг боловсруулж, түүнийгээ сайтар ойлгож, гарын үсэг зурж баталгаажуулах. Хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй, хориглодог гэдгээ ил тод харуулах. Шулуухан байхаас айх хэрэггүй.



Зургийг: Саман Сайди/ Хүүхдийн Ивээх Сан

- Сургуулийн аюулгүй байдлын шалгуур хуудсыг сургууль тус бүрээр гаргаж, улирал тутам хянах;
- Ёс зүйн дүрэм болон Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бодлого журмын механизмыг бий болгохын тулд хамтрагчид/оролцогч талуудын (боловсролын агентлаг/сургууль/орон нутаг) нөөцийг бэхжүүлж, төлөвлөх;

Бие махбодын орон зай дахь эрсдэлүүд

- Сургуулийн барилга доторх тусгаарлагдсан, хаалттай, хараа хяналт муутай газрууд
- Хувийн орон зай байх ёстой ч хамгаалалт муутай, хялбар нэвтрэх боломжтой газрууд (жишээлбэл, хувцас солих өрөө, усан сан, ариун цэврийн өрөө гэх мэт);
- Сургууль эсвэл сургуулийн барилгын хяналт байхгүй орц, гарц (хүүхдийг хэн тосож авч байгаа нь харагддаггүй);
- ТВ, компьютер гэх мэт хүүхэд, насанд хүрэгчдийн хэн хэнийх нь сонирхлыг татахуйц зүйлстэй, хүчирхийлэл үйлдэх газар болгон ашиглаж болзошгүй хараа хяналтгүй анги, бүс;
- Барилгын талбай, их ус, замын хөдөлгөөн, гэрэлтүүлэггүй, дэлбэрээгүй тэсрэх бөмбөг гэх мэт аюул заналхийллийн ойролцоо байх;
- Аюултай, чанар муутай материал ашигласан хүүхдийн тоглоом, тоног төхөөрөмж;
- Сургуулийн бүсэд машин, тээврийн хэрэгсэл эргэх (хүүхдийг мөргөх эрсдэлтэй);
- Сургууль нь цэрэг, цагдаа, зэвсэглэсэн харуулууд зэрэг зэвсэгт хүчинтэй ойрхон байх
- Сургууль руу орох, гарах гарц хангалтгүй
- Сургуулийн барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ариун цэврийн байгууламж муу. Жишээлбэл, бие засах газар сургуулиас хол зайтай байх;
- Хахах, боомилох аюултай тоглоом, эд зүйлс хүүхдийн хүрч болохуйц газар байх;

Эдгээр эрсдэлүүдийг хэрхэн удирдах вэ?

- Сургууль, түр сургалтын бүсэд боловсролын хөтөлбөрийн шинэ барилга барих, үнэлгээ хийхэд аюулгүй байдал ба хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийг татан оролцуулж, эрсдэлтэй газруудыг үнэлэх. Зай талбайг хуваарилж, тохируулга хийхдээ хүүхдийн аюулгүй байдлыг дараах байдлаар харгалзана.
- Хаалга нь цонхгүй, цоожгүй, харанхуй жижиг өрөөнүүдтэй “сохор бүс” байлгахгүй.
- Ойролцоо нь зэвсэгт хүчин, их хэмжээний ус, эгц хадан цохио, хад чулуу унах гэх мэт аюул байхгүй.
- Охид, хөвгүүд, эмэгтэй, эрэгтэй тусдаа бие засах газартай.
- Байгалийн гэрэл сайн тусдаг.
- Сургуулийн орчин, эргэн тойронд гэрэлтүүлэг сайтай.
- Хүүхдүүдийн сургуульдаа ирэх, буцах замд байгаа эрсдэлүүдийг шийдвэрлэнэ.
- Арилжааны бэлгийн мөлжлөг явагддаг газруудын ойролцоо биш.
- Хувцас солих өрөө, усан сан, бие засах газрууд нь тусгаарлалт сайтай.

- Сургуулийн бүс рүү нэвтэрч буй ажилтнууд болон бусад хүмүүсийн хөдөлгөөнийг хянах боломжтой. Сургуулийн талбайд хүүхдүүдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг шалгах, хяналт тавих боломжгүй газар үлдэх эсэхийг сайтар шалгана.
- Тээврийн хэрэгслийг хүүхдүүдээс тусгаарлаж, эргэлт хийх талбай гаргана.
- Хэрвээ хүүхэд сургуульдаа ирж, очихдоо тээврийн хэрэгслээр зорчдог бол:
- Хүүхэд жолоочийн дэргэд, урд суухгүй.
- Жолоочтой ганцаараа явахгүй.
- Бүх жолооч жолооны үнэмлэхтэй, жолоодох эрх нь хүчинтэй байна.
- Тээврийн хэрэгсэл нь явж буй замдаа тохирсон туулах чадвартай байна.
- Тээврийн хэрэгсэл нь суудлын бүстэй, хөдөлгөөнд оролцох үед бүсээ заавал зүүсэн байна.
- Сургуулийн автобус нь галын хор, анхны тусламжийн хайрцгаар тоноглогдсон байна.
- Тээврийн хэрэгсэл дотор ямар ч үед тамхи татахгүй.
- Цонх болон бэхэлгээ нь утас, оосор зэрэг боомилох аюултай зүйлгүй байх. Хагарсан цонхыг наах юм уу, солино. Хагарсан шилийг насанд хүрсэн хүн хаяна.
- Цахилгааны залгуур болон утас нь хүүхэд хүрэхгүй газар байх, ашиглаагүй үедээ залгууруудыг таглах, эсвэл салгасан байна.
- Уртасгагч залгуурын хэрэглээг аль болох бага байлгах ба залгуурыг хэт ачаалж болохгүй. Тээглэж унахаас сэргийлж, дээр нь тэмдэг тавьж, наалт наана.
- Залгуур ба утаснууд нь ус дамжуулах хоолойноос 5-аас доошгүй метр зайтай байна.
- Цахилгаан тэжээлийн эх үүсгэвэр нь зөвхөн гадаа ашиглахад зориулагдсан бөгөөд тухайн талбайгаас аюулгүй зайд, тусгай хашаанд байх ёстой. Ямар ч тохиолдолд хүүхдүүд энэ бүсэд нэвтрэх ёсгүй.
- Агааржуулагч төхөөрөмжийг хашаа, эсвэл хайрцагт хийж, хүүхэд нэвтрэх боломжгүй газар байрлуулна.
- Аюулгүйн стандарт хангаж байгаа эсэхийг шалгаж, жил бүр засвар үйлчилгээ хийх шаардлагатай.



Зургийг: Жи Эм Би Акаш / Хүүхдийг Ивээх Сан

- Хананд суурилуулсан эд хогшил, тавиур, тавилгад аюулгүй, хурц булангийн хамгаалалт хийнэ. Ханын тавилгыг зөвхөн чадварлаг, мэргэжлийн хүн суурилуулж, бэхэлнэ.
- Байгалийн болон хиймэл агааржуулалт хангалттай байна. (халуун, хүйтэн аль аль нь)
- Бие засах газар нь хүйсийн ялгаатай, бүх хүүхдэд хүртээмжтэй байна.
- Бүх бие засах газар гэрэлтүүлэгтэй, хаалга нь цоожтой, цоож нь бүрэн бүтэн ажиллагаатай байна.
- Аюулгүй эрүүл ахуйн дүрэм журмыг мөрдөнө:
- Хүүхдийн өндөрт тохирсон угаалтууртай
- Гар угаах савантай.
- Сурагчийн бүх мэдээлэл, түүний дотор холбон зуучлах маягыг түгжээтэй шүүгээнд хадгална. Түүнийг нээх эрх зөвхөн сургалтын менежер болон нийгмийн ажилтанд байна.
- Янз бүрийн тоног төхөөрөмж ашиглаж, чөлөөтэй тоглож байгаа хүүхдүүдэд хяналт тавина.
- Хүүхдэд хөнгөн зууш өгдөг бол тэр нь тэжээллэг, уух ус нь цэвэр байх ёстой. Хүүхдийг хооллох үед үргэлж хяналт тавьж байна.
- Сургалтын түр байр нь огноотой анхны тусламжийн хэрэгслээр тоноглогдсон байна. Анхны тусламжийн хэрэгслийн хугацааг байнга шалгаж, хугацаа нь дууссан зүйлсийг ашиглахгүй.
- Осолгэмтэл, галтүймэр, эвдрэлээр бүх тохиолдлыг бүртгэж, үйл явдлын дэлгэрэнгүй мэдээлэл, огноо, оролцсон хүмүүсийн нэр, авсан арга хэмжээг тэмдэглэнэ.
- Бүх багш нар анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдсан байх ёстой
- Тоглоом нь хүүхдийн насанд тохирсон, ариутгал цэвэрлэгээ сайтай, хурц ирмэггүй, хортой будаггүй байна. Буу, хутга гэх мэт хүчирхийллийн объектуудын хуулбар тоглоомыг хатуу хориглоно.
- Хахах аюулаас ангид: Хүүхдийн салдаг, эвлүүлдэг тоглоомын эд ангиуд болон бусад бүх тоглоомууд нь хүүхдийн зангидсан гараас том хэмжээтэй байх ёстой. Үлээдэг шаар ашиглахыг хориглоно.



Зургийг: Эндрю Пакуто / Хүүхдийг Ивээх Сан

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Монгол хэл дээр:

1. Анхдугаар хэвлэл ХИС 2019 он, хоёрдугаар хэвлэл ХНХЯ, ХЗДХЯ, “Хамтарсан багийн гишүүдэд зориулсан гарын авлага” 2023 он
2. Анхдугаар хэвлэл ХИС 2019 он, хоёрдугаар хэвлэл ХНХЯ, ХЗДХЯ, “Хамтарсан багийн гишүүдэд зориулсан гарын авлага” 2023 он
3. Анхдугаар хэвлэл ХИС 2019 он, хоёрдугаар хэвлэл ХНХЯ, ХЗДХЯ, “Сургуулийн нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага” 2023 он
4. ХИС, “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгсдэд зориулсан сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагчид ээлтэй үйлчилгээ үзүүлэх арга зүйн багц гарын авлага”, 2024 он
5. ХИС, “Хүүхэд хамгааллын кейс менежментийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн гарын авлага” 2020 он
6. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2024 он
7. Монгол Улсын стандарт, MNS 6949:2021, “Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага”, 2021 он
8. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453-р тушаал, “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”

Англи хэл дээр:

1. Save the Children, “Child Safeguarding Policy”, 2019
2. Save the Children, “Safeguarding children in our education” guidance, 2019
3. Save the Children, “Safe back to School Case Studies”, 2021
4. UNICEF, “COVID-19: Integration of Child Protection in Return to School, Template for Child Protection Referral Pathway between Schools and Child Protection Authorities and Other Services”, 2020
5. FICCI Alliance for Re-Imagining School Education, School Safety & Child Protection Checklist, 2018
6. UK Department for Education, “Keeping children safe in Education”, 2023